ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ГЭРЭЭ
(НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛЖ, ДАХИН ТОДОТГОСОН)

Эрдэнэс МГЛ ХХК

болон

Айвенхоу Оюу Толгой (БиВиАй) Лтд

Оюу Толгой Нидерланд Би.Ви.

Оюу Толгой ХХК (хуучин нэрээр Айвенхоу Майнз Монголия Инк ХХК)

Монгол Улсын Гадаад харилцааны яам
Албан ёсны орчуулга мөн

Гарын үсэг /Signature/ .....
20 11 оны 06 сарын 08 өдөр
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs and Trade of Mongolia
OFFICIAL TRANSLATION

Огноо: 2011 оны 6 дугаар сарын 8-ны өдөр

Гэрээний Талууд:

1. **Эрдэнэс МГЛ ХХК** - Компанийн тухай Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан Төрийн өмчит компани (цаашид "**ТӨК**" гэх).

2. **Айвенхоу Оюу Толгой (БиВиАй) Лтд** - 9 Колумбус Центер Билдинг, Роуд Таун, Тортола, Британийн Виржинийн Арлууд гэх хаягт байрлах, Британийн Виржинийн Арлуудын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан компани (цаашид "**АйВиЭн**" гэх).

3. **Оюу Толгой Нидерланд Би.Ви** - Принс Бернхардплэйн 200, 1097 ЖиБи, Амстердам, Нидерланд гэх хаягт байрлах, Нидерланд Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан компани (цаашид "**ОТН**" гэх)

4. **Оюу Толгой ХХК** (хуучин нэрээр **Айвенхоу Майнз Монголия Инк ХХК)** - Компанийн тухай Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан компани (цаашид "**Компани**" гэх).

Ерөнхий зүйл

Энэхүү Гэрээнд гарын үсэг зурсан өдөр Компанийн Хувь нийлүүлэгчид нь АйВиЭн, ОТН болон ТӨК байх бөгөөд АйВиЭн, ОТН, ТӨК болон Компани нь Компанийн Хувь нийлүүлэгчдийн эрх, үүргийг зохицуулсан 2009 оны 10 дугаар сарын 6-ны өдрийн Хувь нийлүүлэгчдийн гэрээ (**Өмнөх Хувь нийлүүлэгчдийн гэрээ**)-ний Талууд болно.

Өмнөх Хувь нийлүүлэгчдийн гэрээнд гарын үсэг зурсан өдөр Монгол Улсын Засгийн газар болон Компани, Айвенхоу Майнз Лтд, Рио Тинто Интернэшнл Холдингс Лимитед Оюу Толгой Төслийг хэрэгжүүлэх, үйл ажиллагаа явуулах нөхцөл, болзлыг зохицуулах зорилгоор Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан болно.

Хувь нийлүүлэгчид болон Компани нь энэхүү Гэрээг байгуулсан өдрөөр Өмнөх Хувь нийлүүлэгчдийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж, үүнийгээ энэхүү Гэрээнд туссан нөхцөл, болзлын дагуу дахин тодотгож байна.

1. Нэр томъёоны тодорхойлолт

Энэхүү Гэрээнд хэрэглэсэн нэр томъёог энэ Гэрээний 25 дугаар зүйлд заасны дагуу ойлгоно.

2. Энэхүү Гэрээний үйлчлэл

(а) 12(б)-д заасныг харгалзан энэхүү Гэрээг байгуулсан өдрөөр энэ Гэрээ нь Өмнөх Хувь нийлүүлэгчдийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж, түүний нөхцөлүүдийг дахин тодотгоно.

Монгол Улсын Гадаад харилцааны яам
Албан ёсны орчуулга мөн
Гарын үсэг /Signature/ .....
2011 оны 06 сарын 08 өдөр
Улаанбаатар хот
Ministry of Foreign Affairs and Trade
OFFICIAL TRANSLATION

(б) Эргэлзээ төрүүлэхгүй байх үүднээс 12(б)-д заасныг харгалзан Компанийн болон Хувь нийлүүлэгчдийн үйл ажиллагаа нь дараахь баримт бичгүүдээр зохицуулагдаж ирсэн бөгөөд цаашид зохицуулагдана:

(i) энэхүү Гэрээг байгуулсан өдөр хүртэл хугацааны хувьд Өмнөх Хувь нийлүүлэгчдийн гэрээ; болон

(ii) энэхүү Гэрээг байгуулсан өдрөөс хойш энэхүү Гэрээ.

3. Гэрээ хүчин төгөлдөр болох нөхцөл

Талууд энэхүү Гэрээг болон энэхүү Гэрээгээр хүлээх үүрэг (энэ 3 дугаар зүйл болон 4.3(г) (Гэрээний гүйцэтгэлийн үүрэг), 17 дугаар зүйл (Мэдэгдэл ба баталгаа), 23 дугаар зүйл (Маргаан шийдвэрлэх), 24 дүгээр зүйл (Бусад зүйл)-д зааснаас бусад)-ээ гэрээ Хүчин төгөлдөр болох өдөр хүртэл заавал биелүүлэх үүрэг хүлээхгүй.

4. Компанийн хувь эзэмшлийн бүтэц

4.1 Төрийн эзэмшлийн хувьцаа - 34 (гучин дөрвөн) хувь

Гүйцэтгэлийн өдөр ТӨК Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Компанийн Хувьцааны 34 (гучин дөрвөн) хувийг энэхүү Гэрээнд заасан нөхцөлийн дагуу ямар нэг Барьцаагүйгээр эзэмшинэ. ТӨК-ийн Эзэмшлийн энэ хувь хэмжээг өөрөө зөвшөөрснөөс бусад тохиолдолд аливаа шинэ Хувьцаа гаргах замаар бууруулж болохгүй.

4.2 Хувьцаа гаргах

(а) Хөрөнгө оруулалтын гэрээнд Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж (Ашигт малтмалын тухай хууль болон Тогтоолын дагуу) гарын үсэг зурагдсанаар Компани нь Хөрөнгө оруулалтын гэрээний дагуу Оюу толгой төсөлд Монгол Улсын Засгийн газрын оруулах хувь нэмрийг харгалзан Төрийн эзэмшлийн хувьцааг гаргаж ТӨК-д шилжүүлэхээр зөвшөөрөв.

(б) Компани нь Төрийн эзэмшлийн хувьцааг Гүйцэтгэлийн өдөр энэхүү Гэрээнд заасан нөхцөлийн дагуу гаргаж ТӨК-д шилжүүлнэ. Одоогийн бүх Хувь нийлүүлэгчид энэхүү Гэрээний 4-т заасны дагуу гаргасан Төрийн эзэмшлийн хувьцааны хувьд хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэгжүүлэхгүй байхыг зөвшөөрч байна.

4.3 Гэрээний гүйцэтгэлийн үүрэг

(а) Гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 21411 (арван дөрөв) хоногийн дотор Компани нь Төрийн эзэмшлийн хувьцааг Гүйцэтгэлийн өдөр гаргаж ТӨК-д эзэмшүүлэх шийдвэр гаргана.

Монгол Улсын Гадаад харилцааны яам
Албан ёсны орчуулга мөн
Гарын үсэг /Signature/ .....
Ministry of Foreign Affairs and Trade of Mongolia
OFFICIAL TRANSLATION

(б) Төрийн эзэмшлийн хувьцааг Гүйцэтгэлийн өдөр гаргаж ТӨК-д эзэмшүүлэхэд шаардлагатай бүх арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүргийг Компани хүлээнэ.

(в) Компани нь Гүйцэтгэлийн өдөр Улаанбаатар хотод дараахь зүйлийг хийж гүйцэтгэнэ:

(i) Төрийн эзэмшлийн хувьцааг гаргаж ТӨК-д шилжүүлсэн тухай Компанийн бүртгэлд бүртгэх;

(ii) Төрийн эзэмшлийн хувьцааны гэрчилгээг ТӨК-д хүргүүлэх;

(iii) Төрийн эзэмшлийн хувьцааг гаргаж ТӨК-д шилжүүлснийг бүртгүүлэхтэй холбогдсон баримт бичгүүдийг Улсын бүртгэлийн ерөнхий газар болон Гадаадын хөрөнгө оруулалтын газарт тус тус хүргүүлэх.

(г) Гүйцэтгэлийн өдрөөс өмнө ТӨК болон Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид нь энэхүү Гэрээний 5.3(а)-д заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилуулах нэр дэвшигчдийнхээ тухай Компанид болон нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ. Тухайн нэр дэвшигчийг Гүйцэтгэлийн өдөр Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилогдсонд тооцно.

4.4 Гүйцэтгэлийн өдрийн ТӨК-ийн Эзэмшлийн хувь хэмжээ

Төрийн эзэмшлийн хувьцаа гаргаж ТӨК-д шилжүүлснээр ТӨК-ийн Эзэмшлийн хувь хэмжээ нь Компанийн нийт Хувьцааны 34 (гучин дөрвөн) хувь байна.

5. Компанийн үйл ажиллагаа ба удирдлага

5.1 Компанийн үйл ажиллагааны хүрээ

Компани нь хуулиар хориглоогүй аливаа үйл ажиллагааг эрхэлж болох бөгөөд Үндсэн үйл ажиллагаатай холбоотой үйл ажиллагаа явуулахад шаардлагатай эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

5.2 Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх

Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "**ТУЗ**" гэх) нь энэхүү Гэрээний 5.10(а)-д заасан Хувь нийлүүлэгчдийн хурлын онцгой эрхэд хамааруулснаас бусад Компанийн үйл ажиллагаатай холбоотой аливаа асуудлыг шийдвэрлэх эрхтэй.

5.3 ТУЗ-ийн гишүүд

(а) Гүйцэтгэлийн өдөр ТУЗ-ийн гишүүдийг томилохдоо ТӨК 3 (гурав), Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид 6 (зургаан) ТУЗ-ийн гишүүнийг

Монгол Улсын Гадаад харилцааны яам
Албан ёсны орчуулга мөн
Гарын үсэг /Signature/ .....
2011 оны 05 сарын 08
Улаанбаатар хот

энэхүү Гэрээний 5.3(б)-д заасны дагуу тус тус нэр дэвшүүлэх эрхтэй болохыг Талууд хүлээн зөвшөөрч байна.

(б) Энэхүү Гэрээний 5.3(в)-д заасныг баримтлан 10 (арав) болон түүнээс дээш Эзэмшлийн хувь хэмжээтэй Хувь нийлүүлэгч бүр өөрийн Эзэмшлийн хувь хэмжээнд ногдох тоог 10 (арав)-т хуваасантай тэнцүү тооны хүнийг ТУЗ-ийн гишүүнд томилуулахаар тухай бүр шууд нэр дэвшүүлэх, чөлөөлөх эрхтэй. Энэхүү тооцоогоор гарах бутархай тоог ТУЗ-ийн гишүүдийн тоог тодорхойлоход тооцохгүй;

(в) Энэхүү Гэрээний 5.3(б)-д заасан Хувь нийлүүлэгчийн Эзэмшлийн хувь хэмжээг тодорхойлохдоо тухайн Хувь нийлүүлэгч болон түүнтэй Хамаарал бүхий компанийн эзэмшиж буй хувьцааг нэгтгэн тооцох бөгөөд ийнхүү нэгтгэсэн Эзэмшлийн хувь хэмжээ нь тухайн Хувь нийлүүлэгчдэд Гэрээний 5.3(б)-д заасан эрхийг хамтаар (нэг буюу түүнээс дээш тооны Хувь нийлүүлэгчээрээ төлөөлүүлэн) хэрэгжүүлэх эрх олгоно;

(г) Энэхүү Гэрээний 5.3(б)-д заасны дагуу тухай бүр ТУЗ-ийн гишүүнд санал болгосон нэр дэвшигчдийг энэхүү Гэрээний 5.10(б)-д заасны дагуу Хувь нийлүүлэгчдийн дараагийн хурлаар томилох бөгөөд Хувь нийлүүлэгч бүр нөгөө талаас дэвшүүлсэн нэр дэвшигчийг дэмжсэн санал өгнө;

(д) ТУЗ-ийн гишүүн бүр өөрийн түр эзгүйд, эсхүл өвчтэй байх хугацаанд болон бусад шалтгаанаар ТУЗ-ийн гишүүний үүргээ биелүүлж чадахгүй байх хугацаанд, түүнчлэн тодорхой нөхцөл байдал үүсэх хүртэл өөрийгөө орлох этгээдийг томилж болно. Уг томилолтыг бичгээр үйлдэж, тухайн томилж буй ТУЗ-ийн гишүүн гарын үсэг зурж хувийг нь Компанид хүргүүлнэ;

(е) Хувь нийлүүлэгч нь ТУЗ-д өөрийн санал болгож томилуулсан ТУЗ-ийн гишүүнээ бусад Хувь нийлүүлэгчдэд мэдэгдсэнээр өөрчилж болох бөгөөд уг томилгоог Хувь нийлүүлэгчдийн хурлаар батална.

5.4 Санал өгөх

ТУЗ-ийн гишүүн бүр саналын 1 (нэг) эрхтэй байна.

5.5 ТУЗ-д томилогдсон гишүүд

ТУЗ-ийн гишүүн нь үүргээ биелүүлэхдээ Компанийн ашиг сонирхолд дээд зэргээр нийцүүлэн үнэнч шударгаар ажиллана. Компанийн ТУЗ-ийн гишүүний хувьд ТУЗ-ийн гишүүн нь өөрийн үүргээ биелүүлэх, өөрт олгогдсон эрх мэдэл, давуу байдлаа хэрэгжүүлэхдээ өөрийг нь томилсон Хувь нийлүүлэгчийн ашиг сонирхлыг харгалзах үүднээс хандаж, түүний хүсэлд тулгуурлан үйл ажиллагаа явуулж болно.

Монгол Улсын Гадаад хэрэг эрхлэх яам
Албаны эсэхийг гэрчилсэн
Гарын үсэг /Signature/ .....
2011 оны 06 сарын 08 өдөр
Улаанбаатар хот
Ministry of Foreign Affairs and [illegible] Mongolia
OFFICIAL [illegible]

5.6 ТУЗ-ийн хурал

(а) ТУЗ-ийн хурлыг улиралд 1 (нэг) удаа хуралдуулна. Аливаа 3 (гурван) ТУЗ-ийн гишүүний хүсэлтээр түүнээс олон удаа хуралдуулж болно. Онцгой байдал үүссэнээс бусад тохиолдолд хамгийн сүүлийн хурлаас хойш 30 (гуч) хоногийн дотор дараагийн хурлыг хуралдуулахыг 3 (гурван) ТУЗ-ийн гишүүн шаардах эрхгүй. ТУЗ-ийн шийдвэрт өөрөөр заагаагүй бол:

(i) ТУЗ-ийн бүх хурлыг Улаанбаатар хотод хийнэ;

(ii) ТУЗ-ийн хурлын зарыг гишүүдэд 21 (хорин нэг)-ээс доошгүй хоногийн өмнө хүргүүлнэ.

ТУЗ-ийн шийдвэрийн дагуу хурлыг видео конференс болон харилцаа холбооны ижил төрлийн шууд дамжуулах бусад технологийг ашиглан хийж болох бөгөөд уг хурлыг Улаанбаатар хотод хийсэнд тооцно.

(б) ТУЗ-ийн хурлын зар мэдээнд тусгагдах ёстой бусад зүйлээс гадна тухайн хурлаар хэлэлцэх асуудал бүрийн талаарх зохих хэмжээний дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан хэлэлцэх асуудлыг тусгаж, холбогдох бусад баримт бичгийг хавсаргана. ТУЗ-ийн гишүүн бүр зөвшөөрч өөрөөр тохиролцоогүй бол ТУЗ-ийн хурлаар зөвхөн хэлэлцэх асуудалд тусгасан асуудлыг хэлэлцэнэ.

(в) Хувь нийлүүлэгчид өөрийн томилсон ТУЗ-ийн гишүүний ТУЗ-ийн хуралд оролцохоор хүрэлцэн ирэх, буцах замын болон холбогдох бусад зардал, гишүүнийхээ үүргийг гүйцэтгэхтэй холбоотой бүх зардлыг хариуцна. Оюу толгой төслийн талбайд ТУЗ-ийн хурлыг хийх тохиолдолд Компани нь ТУЗ-ийн гишүүдийн Улаанбаатар хотоос очих, буцах тээвэр, байр, хоолны зардлыг хариуцна.

(г) ТУЗ-ийн хуралд ТУЗ-ийн нийт гишүүний Дийлэнх олонхи (үүнд Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид болон ТӨК-ийн томилсон тус бүр 1 (нэг)-ээс доошгүй гишүүн заавал оролцсон байх шаардлагатай) оролцсон (биечлэн, эсхүл өөрийгөө төлөөлүүлэн)-оор хурлын ирц бүрдэнэ. ТУЗ-ийн хурлын ирц бүрдээгүй тохиолдолд хурлыг хойшлуулахаас өөр асуудал хэлэлцэхгүй.

(д) ТУЗ-ийн хурлын ирц зар мэдээнд заасан хурал эхлэх хугацаанаас хойш 30 (гуч) минутын дотор бүрдээгүй тохиолдолд тухайн хурлыг 2 (хоёр) өдрөөр хойшлуулна. Хойшилсон хурлын хэлэлцэх асуудалд өөрчлөлт оруулж болохгүй. Хойшлогдсон хурлын ирц ТУЗ-ийн нийт гишүүний Дийлэнх олонхи хүрэлцэн ирснээр бүрдэнэ.

Монгол Улсын Гадаад харилцааны яам
Албан ёсны орчуулгад мөн
Гарын үсэг /Signature/ .....
2011 оны 06 сарын 08 өдөр
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs and Trade of Mongolia
OFFICIAL TRANSLATION

5.7 ТУЗ-ийн дарга

(а) Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид өөрсдийн томилсон ТУЗ-ийн гишүүдийн дундаас нэг гишүүнийг ТУЗ-ийн даргаар томилж болно.

(б) ТУЗ-ийн аливаа хуралд ТУЗ-ийн дарга хүрэлцэн ирээгүй бол Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид тухайн хурлыг удирдуулахаар өөрсдийн томилсон ТУЗ-ийн гишүүдийн дундаас 1 (нэг) гишүүнийг томилж болно.

(в) ТУЗ-ийн хурал дээр аливаа асуудлаар ТУЗ-ийн гишүүдийн санал тэнцвэл ТУЗ-ийн дарга тухайн асуудлыг эцэслэн шийдвэрлэх саналын эрхтэй байна.

5.8 ТУЗ-ийн шийдвэр

ТУЗ-ийн хурлаас гарах аливаа тогтоол, эсхүл шийдвэрийг тухайн хуралд (биечлэн, эсхүл өөрийгөө төлөөлүүлэн) оролцож байгаа саналын эрхтэй ТУЗ-ийн гишүүдийн Дийлэнх олонхийн дэмжсэн саналаар гаргана.

5.9 ТУЗ-ийн хороод

ТУЗ шаардлагатай гэж үзвэл тухайлсан асуудал хариуцсан 1 (нэг) буюу хэд хэдэн ТУЗ-ийн хороо байгуулж болно.

5.10 Хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэр

(а) Энэхүү Гэрээний 5.2-т заасан Компанийн үйл ажиллагаатай холбоотой ТУЗ-ийн бүрэн эрхэд хамаарах бүх асуудлаас бусад буюу энэхүү Гэрээний 5.10(а)-д заасан дор дурдсан асуудлыг Хувь нийлүүлэгчдийн хурлын бүрэн эрхийн хүрээнд хэлэлцэж шийдвэрлэнэ. Үүнд:

(i) Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;

(ii) нийлэх, нэгдэх, хуваах, эсхүл өөрчлөх замаар Компанийг өөрчлөн байгуулах;

(iii) Компанийн өрийг Хувьцаагаар солих;

(iv) Компанийн хэлбэрийг өөрчлөх замаар Компанийг өөрчлөн байгуулах;

(v) Компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;

(vi) Компанийн Хувьцааг хуваах, эсхүл нэгтгэх;

Монгол Улсын Гадаад харилцааны яам
Гарын үсэг /Signature/ .....
2011 оны 06 сарын 08-ны өдөр
Улаанбаатар хот
ЭРДЭНЭС МГЛ ХХ КОМПАНИ

(vii) Энэхүү Гэрээний 6-д заасныг баримтлан Компанийн тухай Монгол Улсын хуулийн 12 дугаар бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах;

(viii) ТУЗ-ийн гишүүдийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;

(ix) Хянан шалгах зөвлөлийн гишүүдийг томилох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;

(x) энэхүү Гэрээний 4.2, 10.2, 10.3, 11.1-д заасныг баримтлан Хувь нийлүүлэгчид Компанийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн дагуу Компанийн хувьцаа, эсхүл бусад үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах эрх эдлэх эсэх;

(xi) Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн жилийн тайлангийн талаархи ТУЗ-ийн гаргасан тайланг хэлэлцэж батлах;

(xii) Компанийн тухай Монгол Улсын хуулийн 11 дүгээр бүлэгт заасан их хэмжээний хэлцлийг батлах;

(xiii) Компанийн тухай Монгол Улсын хуулийн дагуу Компани өөрийн хувьцаагаа худалдан авахыг зөвшөөрөх;

(xiv) Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол ТУЗ-ийн гишүүдэд олгох цалин хөлс, урамшууллын хэмжээг тогтоох;

(xv) Хувь нийлүүлэгчдийн хуралд ТУЗ-өөс оруулсан бусад асуудал;

(xvi) Компанийн тухай Монгол Улсын хууль, эсхүл Компанийн дүрэмд заасны дагуу хувь нийлүүлэгчдийн хурлаар батлуулах шаардлагатай бусад асуудал.

(б) Энэхүү Гэрээний 5.10(a)(i)-аас 5.10(a)(vii) (5.10(a)(vii)-г оруулж тооцно)-д заасан Хувь нийлүүлэгчдийн хурлаар шийдвэрлэх шаардлагатай асуудлыг тухайн хуралд оролцож байгаа нийт саналын эрхийн Дийлэнх олонхийг эзэмшиж буй Хувь нийлүүлэгчид, эсхүл Хувь нийлүүлэгчийн төлөөлөгчдийн дэмжсэн саналаар шийдвэрлэнэ. Энэхүү Гэрээний 5.10(a)-д заасан бусад бүх асуудлыг тухайн хуралд оролцож байгаа нийт саналын эрхийн олонхийг эзэмшиж буй Хувь нийлүүлэгчид, эсхүл Хувь нийлүүлэгчийн төлөөлөгчдийн дэмжсэн саналаар шийдвэрлэнэ.

(в) Хувь нийлүүлэгчдийн хурлыг хуралдуулах тухай ТУЗ-ийн шийдвэрт Хувь нийлүүлэгчдийн товлосон хурлын зарыг Хувь нийлүүлэгчдэд доод тал нь 2 (хоёр) долоо хоногийн өмнө хүргүүлсэн байх талаар тусгана.

Монгол Улсын Гадаад харилцааны яам
Албан ёсны орчуулга мөн
Гаргуулагч ...
2011 оны 06 сарын 08 өдөр
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs and Trade of Mongolia
OFFICIAL TRANSLATION

(г) ТӨК-аас 1 (нэг) төлөөлөгч, Айвенхоугийн Хувь нийлүүлэгчдээс 1 (нэг) төлөөлөгч хүрэлцэн ирснээр Хувь нийлүүлэгчдийн хурлын ирц бүрдэнэ. Хувь нийлүүлэгчдийн хурал эхлэхэд ирц бүрдээгүй бол Хувь нийлүүлэгчдийн аливаа хурлаар тухайн хурлыг хойшлуулахаас өөр ямар ч асуудлыг шийдвэрлэхгүй.

(д) Хэрэв Хувь нийлүүлэгчдийн хурлын ирц зар мэдээнд заасан эхлэх цагаас хойш 30 (гучин) минутын дотор бүрдээгүй бол тухайн хурал дараа долоо хоногийн мөн өдөр, цаг, газарт хуралдахаар хойшлогдоно. Хойшилсон хурлын хэлэлцэх асуудалд өөрчлөлт оруулж болохгүй. Хэрэв хойшилсон хурлын ирц товлосон хугацаанаас хойш 30 (гучин) минутын дотор бүрдээгүй бол тухайн хурал дараа долоо хоногийн мөн өдөр, цаг, газарт хуралдахаар дахин хойшлогдоно. Дахин хойшилсон хурлын хэлэлцэх асуудалд өөрчлөлт оруулж болохгүй. Хоёр дахь удаагаа хойшилсон хурлын ирц Компанийн Хувьцааны 20 (хорь)-оос доошгүй хувийг эзэмшдэг, саналын эрхтэй Хувь нийлүүлэгч, эсхүл Хувь нийлүүлэгчдийн төлөөлөгч буюу төлөөлөгчид хүрэлцэн ирснээр бүрдэнэ.

5.11 Хувь нийлүүлэгчид санал өгөх

Хувь нийлүүлэгч бүр өөрийн эзэмшиж буй Хувьцааны тоотой тэнцүү саналын эрхтэй байна.

5.12 Дотоодоос ханган нийлүүлэх үүрэг

Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн үйлчилгээ болон Монгол Улсад байгаа тоног төхөөрөмж, түүхий эд, хангамжийн материал, сэлбэг хэрэгслийн үнэ өртөг, нийлүүлэх хугацаа, тоо хэмжээ, чанарын хувьд өрсөлдөхүйц байх тохиолдолд Компани тэдгээрийг тэргүүн ээлжинд худалдан авна. Өмнөговь аймагт үйл ажиллагаа явуулж буй бизнесийн байгууллагуудыг тэргүүн ээлжинд авч үзэхийн зэрэгцээ Оюу толгой төсөлд шаардагдах ачаа болон тээвэрлэлтийн үйлчилгээг Монгол талын нийлүүлэгчдээр тэргүүн ээлжинд гүйцэтгүүлнэ.

6. Сонирхлын зөрчилтэй хэлцэл

6.1 Компанийн тухай хуулийн 12 дугаар бүлгийг хэрэглэх

Энэхүү Гэрээний 6.2-т зааснаас бусад тохиолдолд сонирхлын зөрчилтэй хэлцэлд хамаарах Компанийн тухай Монгол Улсын хуулийн заалтууд, түүний дотор уг хуулийн 12 дугаар бүлгийг Компанийн үйл ажиллагаанд мөрдөнө.

6.2 Хамааралтай хэлцэл

Компанийн тухай Монгол Улсын хуулийн 86.4-т зааснаас бусад тохиолдолд Компани болон нөгөө талаас аль нэг Хувь нийлүүлэгч, эсхүл түүний Хамаарал бүхий компанийн хооронд хийгдэх аливаа хэлцэлд Компанийн тухай хуулийн 12 дугаар бүлгийн заалтыг хэрэглэхгүй гэж Компанийн

Монгол Улсын Гадаад харилцааны яам
Албан ёсны орчуулга мөн
Гарын үсэг /Signature/ .....
20 11 06 08

дүрэмд тусгана. Хамааралтай хэлцлийн хувьд дараахь заалтуудыг баримтална:

(а) Хувь нийлүүлэгчдээс урьдчилан зөвшөөрөл авахгүйгээр Компани нь Хамааралтай хэлцэл хийж болох бөгөөд аливаа Хамааралтай хэлцэл нь:

(i) зах зээлийн өрсөлдөхүйц үнээр хийгдсэн байх ёстой;

(ii) харилцан хамааралгүй этгээдүүдийн хооронд тохиролцох арилжааны нөхцөлтэй дүйцэхүйц нөхцөлөөр хийгдсэн байх ёстой;

(iii) Хувь нийлүүлэгчдэд шуурхай мэдээлэгдсэн байх ёстой.

(б) ТУЗ-ийн гишүүн бүр аливаа Хамааралтай хэлцлийн талаар саналаа өгнө. Хэрэв аль нэг Хувь нийлүүлэгч уг хэлцлийг энэхүү Гэрээний 6.2(а)-д заасан шаардлагыг хангаагүй гэж үзвэл Компани болон бусад Хувь нийлүүлэгчдэд мэдэгдэл өгч болно. Энэ тохиолдолд дараахь заалтуудыг баримтална:

(i) Тухайн Хувь нийлүүлэгч мэдэгдлээ Хамааралтай хэлцлийн талаар мэдээлэл авсан өдрөөс хойш 30 (гуч) хоногийн дотор хүргүүлэх бөгөөд уг мэдэгдэлдээ тухайн хэлцэл ямар үндэслэл, шалтгаанаар энэхүү Гэрээний 6.2(а)-д заасан шалгуурыг хангахгүй байна гэж үзэж байгаагаа дурдсан байна;

(ii) Тухайн Хамааралтай хэлцлийг ТУЗ-ийн дараагийн хурлаар хэлэлцэнэ;

(iii) Хэрэв Хувь нийлүүлэгч ТУЗ-ийн хурлаар хэлэлцсэн Хамааралтай хэлцлийн хэлэлцүүлэгт сэтгэл ханамжгүй байгаа бол тэрээр энэ тухай мэдэгдлээ уг хурал болсноос хойш 7 (долоо) хоногийн дотор бусад Хувь нийлүүлэгч болон ТУЗ-д өгнө. Үүний дараа Хувь нийлүүлэгчид тухайн Хамааралтай хэлцэл энэхүү Гэрээний 6.2(а)-д заасан шаардлагыг хангаж байгаа эсэх талаар үнэлгээ хийлгэхээр зохих шалгуурыг хангасан хараат бус шинжээчийг хамтран томилно;

(iv) Хэрэв Хувь нийлүүлэгчид энэхүү Гэрээний 6.2(б)(iii)-д заасан мэдэгдэл өгснөөс хойш 15 (арван тав) хоногийн дотор хараат бус шинжээчийг томилох талаар тохиролцож чадаагүй бол тухайн шинжээчийг Хувь нийлүүлэгчдийн харилцан зөвшөөрсөн, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, нэр хүнд бүхий аудитын болон нягтлан бодох бүртгэлийн компани сонгоно;

Монгол Улсын Гадаад харилцааны яам
Албан ёсны орчуулга мөн
Гарын үсэг /Signature/ .....
2011 оны 06 сарын 08-ны өдөр
Улаанбаатар хот
Ministry of Foreign Affairs of Mongolia
OFFICIAL TRANSLATION

(v) Хараат бус шинжээч Хамааралтай хэлцлийг энэхүү Гэрээний 6.2(а)-д заасан шалгуурыг хангахгүй байна гэж тогтоох тохиолдолд тухайн Хамааралтай хэлцлийг хүчингүйд тооцохгүй. Гэхдээ тухайн Хамааралтай хэлцлийн нэг тал болох Хувь нийлүүлэгч (эсхүл түүний Хамаарал бүхий компани нь Хамааралтай хэлцлийн нэг тал бол) энэхүү Гэрээний 6.2(а)-д заасан шалгуурыг хангаагүйн улмаас Компанид учирсан аливаа хохирлыг хариуцна;

(vi) Хараат бус шинжээчийн гаргасан дүгнэлтээс үл хамааран уг шинжээчийн бүх зардлыг Компани хариуцна.

(в) Хувь нийлүүлэгчийн хүсэлтээр Компани болон бусад Хувь нийлүүлэгч нь энэхүү Гэрээний 6.2(а)-д заасан шалгуурыг Хамааралтай хэлцэл хангаж байгааг харуулах зохих түвшний шаардлагатай мэдээллээр тухайн Хувь нийлүүлэгчийг хангана.

7. Гүйцэтгэх удирдлага болон Менежментийн баг

7.1 Гүйцэтгэх удирдлага

Компанийн гүйцэтгэх удирдлага нь Компанийн удирдах албан тушаалтнуудаас бүрдэх бөгөөд Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцна.

7.2 Менежментийн баг

(а) ТУЗ нь АйВиЭн, эсхүл ОТН буюу тэдгээрийн нэг буюу түүнээс дээш Хамаарал бүхий компанийг дангаар нь, эсхүл бүлэг болгон хамтад нь (цаашид "**Менежментийн баг**" гэх) авч ажиллуулна. Менежментийн баг нь энэхүү Гэрээний 7.1-д заасан гүйцэтгэх удирдлагад Компанийн үйл ажиллагаа, түүний дотор Үндсэн үйл ажиллагааг эрхлэн явуулахад нь туслалцаа, үйлчилгээ үзүүлнэ.

(б) Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид нь Менежментийн багийг өөрчлөх саналыг тухай бүр гаргаж болох бөгөөд ТУЗ нь санал болгосон Менежментийн багийг өөрчилж, томилох асуудлыг шийдвэрлэнэ.

(в) Гүйцэтгэх удирдлага Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулахад Менежментийн багаас үзүүлэх үйлчилгээ, туслалцаа нь инженеринг, үйл ажиллагаа, төлөвлөлт болон үнэлгээ, байгаль орчин, маркетинг, ханган нийлүүлэлт, хууль зүй, худалдаа, төлбөр тооцоо, санхүүгийн үйлчилгээ, түүнчлэн Үндсэн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахад шаардлагатай гэж үзсэн бусад бүхий л үйлчилгээнээс бүрдэж болно.

Гадаад Улсын Газар, харилцаа, ... яам
Албан ёсны орчуулга мөн
Гарын үсэг /Signature/ .....
2011 оны 06 сарын 08-ны өдөр
Улаанбаатар хот
Ministry of Foreign Affairs and Trade of ...
OFFICIAL TRANSLATION

7.3 Менежментийн багийн чиг үүрэг

(а) Менежментийн баг нь энэхүү Гэрээний 7.1-д заасан гүйцэтгэх удирдлагын зүгээс Компанийн үйл ажиллагаа, түүний дотор Үндсэн үйл ажиллагааг эрхлэн явуулахад шаардлагатай туслалцаа, үйлчилгээ үзүүлэх бүхий л эрх, эрх мэдэлтэй байна;

(б) ТУЗ нь шаардлагатай, эсхүл зүйтэй гэж үзвэл Менежментийн багийн үйл ажиллагаанд хяналт тавих бөгөөд түүнтэй холбоотой ажиллана. Менежментийн баг Компанийн үйл ажиллагааны талаар ТУЗ-д улирал тутам бичгээр тайлагнана. Менежментийн багийг хариуцан ажиллаж буй этгээд (эсхүл түүний эзгүйд төлөөлөгч нь) энэхүү Гэрээний 5.6(а)-д заасан ТУЗ-ийн улирал тутмын хуралд оролцоно. Тайланг тухайн Улирал дууссанаас хойш 30 (гуч) хоногийн дотор ТУЗ-д хүргүүлнэ.

7.4 Менежментийн үйлчилгээний төлбөр

(а) Компани нь Менежментийн багт Менежментийн үйлчилгээний төлбөрийг төлнө;

(б) Менежментийн үйлчилгээний төлбөрийг улирал бүрээр тооцож, тухайн улирлын эцсийн өдрөөс хойш 10 (арван) Ажлын өдрийн дотор төлнө;

(в) Менежментийн үйлчилгээний төлбөрийн хэмжээ нь:

(i) Гэрээ хүчин төгөлдөр болох өдрөөс эхлэн Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эхэлсэн өдөр хүртэлх хугацаанд тухайн хугацаанд гарсан Үндсэн хөрөнгийн зардал болон Үйл ажиллагааны зардлын нийт дүнгийн 3 (гурван) хувь;

(ii) Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эхэлсэн өдрөөс хойшхи хугацаанд гарсан Үндсэн хөрөнгийн зардал болон Үйл ажиллагааны зардлын нийт дүнгийн 6 (зургаан) хувь байна.

(г) Хувь нийлүүлэгчид нь тухайн Санхүүгийн жилийн аудит хийлгэсэн санхүүгийн тайлан гармагц аль болох хурдан хугацаанд уг тайланд тусгасан Үндсэн хөрөнгийн болон Үйл ажиллагааны зардлыг тухайн Санхүүгийн жилийн Менежментийн үйлчилгээний төлбөрийг тооцохдоо ашигласан Үндсэн хөрөнгийн болон Үйл ажиллагааны зардалтай тулгана. Аудитыг ТУЗ-өөс томилсон, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, нэр хүнд бүхий аудитын болон нягтлан бодох бүртгэлийн компаниар хийлгэнэ. Хэрэв зөрүү гарвал Компани, эсхүл Менежментийн баг (тухайн тохиолдлоос хамаарч төлөх ёстой тал) нь тухайн Санхүүгийн жилд төлсөн Менежментийн үйлчилгээний төлбөрийн зөрүүг арилгах зорилгоор холбогдох төлбөрийг нөгөө талдаа шуурхай төлнө.

Албан ёсны орчуулга мөн
Гарын үсэг /Signature/
2011 оны 06 сарын 08 өдөр
Улаанбаатар хот
Ministry of Foreign Affairs and Trade
ЭРДЭНЭС ХХК

(д) Менежментийн баг нь өөрийн үйлчилгээний тодорхой хэсгийг болон дэмжих чиг үүргээ АйВиЭн, эсхүл ОТН-ийн Хамаарал бүхий компанид шилжүүлэх, эсхүл тэдгээрээр туслан гүйцэтгүүлж болно. Хэрэв Менежментийн баг ингэж шийдвэрлэвэл Компани нь тухайн чиг үүрэгт (Менежментийн багийн тодорхойлсноор) хамаарах Менежментийн үйлчилгээний төлбөрийн холбогдох хэсгийг АйВиЭн, эсхүл ОТН-ийн Хамаарал бүхий компанид шууд төлнө. Түүнчлэн Менежментийн баг нь Менежментийн үйлчилгээний төлбөрийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн Айвенхоу групп, эсхүл Рио Тинто группын аль нэг гишүүнд шууд төлөхийг Компанид бичгээр даалгаж болно.

(е) ТУЗ нь Санхүүгийн жил бүрийн сүүлчийн Улиралд тухайн Санхүүгийн жил дэх Менежментийн багийн үүргийн гүйцэтгэлийг авч хэлэлцэнэ.

(ё) Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид хамтдаа, эсхүл тэдгээрийн аль нэг нь Менежментийн багийг төлөөлж болон түүний нэрийн өмнөөс энэхүү Гэрээг хэрэгжүүлж болно (тухайлбал энэхүү Гэрээний 23-т заасан маргааны талаар мэдэгдэл гаргах замаар).

8. Төсөв болон санхүүгийн мэдээлэл

8.1 Жилийн төлөвлөгөө болон төсөв

(а) Компани (эсхүл Менежментийн баг) нь Гүйцэтгэлийн өдрөөс хойш 10 (арав) Ажлын өдрийн дотор тухайн Санхүүгийн жилийн үлдэж байгаа хугацааны Компанийн үйл ажиллагааны анхны хөтөлбөр, төсвийг ТУЗ-д хүргүүлнэ. ТУЗ нь тухайн хөтөлбөр, төсвийг хэлэлцэж шийдвэрлэх зорилгоор хуралдана;

(б) Үүнээс хойш Компани (эсхүл Менежментийн баг) нь Санхүүгийн жил эхлэхээс өмнө тухайн Санхүүгийн жилд хэрэгжүүлэх Компанийн үйл ажиллагааны хөтөлбөр болон төсвийн төслийг жил бүр боловсруулж ТУЗ-д батлуулахаар хүргүүлнэ.

(в) ТУЗ тухайн Санхүүгийн жил эхлэхээс доод тал нь 30 (гуч)-аас доошгүй хоногийн өмнө үйл ажиллагааны хөтөлбөр бүр болон төсвийг хэлэлцэн шийдвэрлэнэ. Хөтөлбөр болон төсвийг баталснаар Компани болон Менежментийн баг нь тухайн хөтөлбөр болон төсвийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүх арга хэмжээг авч, зөвшөөрөгдсөн бүх зарлагыг гаргах эрхтэй болно.

(г) Шаардлагатай тохиолдолд Компани (эсхүл Менежментийн баг) нь шинэчлэн найруулсан, эсхүл нэмэлт оруулсан хөтөлбөр болон төсвийг боловсруулж ТУЗ-д батлуулахаар хүргүүлж болно.

Монгол Улсын Гадаад харилцааны яам
Албан ёсны орчуулга мөн
Гарын үсэг /Signature/ .....
2011 оны 06 сарын 08 өдөр
Улаанбаатар хот
Ministry of Foreign Affairs and Trade
OFFICIAL TRANSLATION

8.2 Санхүүгийн мэдээлэл

Компани нь ТУЗ-ийн гишүүн болон Хувь нийлүүлэгч бүрийг дараахь мэдээллээр хангана:

(а) хуанлийн сар бүр дуусмагц аудит хийлгээгүй менежментийн тайлан;

(б) Санхүүгийн жил бүр дуусмагц аудит хийлгэсэн Компанийн санхүүгийн тайлангийн хувь;

(в) жилийн үйл ажиллагааны хөтөлбөр, төсвийг батлах үед эх үүсвэрийн төлөв, ирэх 12 сарын хугацаанд бэлэн мөнгийг хэрхэн зарцуулах талаар тусгасан Компанийн бэлэн мөнгөний хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон жилийн төлөвлөгөө;

(г) Хувь нийлүүлэгчид, эсхүл ТУЗ-ийн гишүүн тухай бүр үндэслэлтэйгээр авахыг шаардсан аливаа бусад мэдээлэл.

8.3 Менежментийн тайлан

Компани нь Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим (НББНХЗЗ), эсхүл Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС) болон Монгол Улсын нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартад нийцүүлэн өөрийн менежментийн тайланг хөтөлнө.

9. Компанийн санхүүжилт

9.1 Шаардсан мөнгөн хөрөнгө

Компани (эсхүл түүний нэрийн өмнөөс Менежментийн баг) нь ТУЗ-ийн баталсан хөтөлбөр болон төсвийн хүрээнд Компанид шаардагдаж буй мөнгөн хөрөнгийн хэрэгцээг хангах зорилгоор Хувь нийлүүлэгчдэд өөрийн Эзэмшлийн хувь хэмжээндээ тэнцүүлэн хөрөнгө (цаашид тус бүрийг "**Шаардсан мөнгөн хөрөнгө**" гэх) оруулах хүсэлтийг бичгээр тавьж болно. Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид хүсэлт гаргасан тохиолдолд Шаардсан мөнгөн хөрөнгийн мэдэгдлийг Айвенхоугийн Хувь нийлүүлэгчдийн зөвшөөрсөн хувь хэмжээгээр бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн төлүүлэхээр нэг, эсхүл түүнээс дээш Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид хүргүүлнэ (жишээлбэл, ОТН болон АйВиЭн-ээс төлөх нийт Шаардсан мөнгөн хөрөнгийг нэгтгэн төлөх тухай мэдэгдлийг ОТН-д өгсөн бол АйВиЭн-д Шаардах мөнгөн хөрөнгийн мэдэгдэл өгөхгүй).

9.2 Шаардсан мөнгөн хөрөнгийн санхүүжилт

Талууд Шаардсан мөнгөн хөрөнгийг ТУЗ-өөс тухай бүрд тодорхойлсон арга хэлбэр (эсхүл хослуулсан арга хэлбэр)-ээр санхүүжүүлэхийг эрмэлзэнэ. Үүнд:

(а) энгийн хувьцааны хэлбэрээр (Хувьцаа нэмж гаргах замаар);

Монгол Улсын Гадаад харилцааны яам
Албан ёсны орчуулга мөн
Гарын үсэг /Signature/
Улаанбаатар хот

(б) өрийн хэлбэрээр (Хувь нийлүүлэгчийн өрийн хэлбэрээр).

Санхүүжилтийн хугацаанд энэхүү Гэрээний 11, 12 болон 13 дугаар зүйлүүд үйлчилнэ.

9.3 Шаардсан мөнгөн хөрөнгийг нийлүүлэх

(а) Шаардсан мөнгөн хөрөнгийг нийлүүлэх Айвенхоугийн Хувь нийлүүлэгчийн үүргийг АйВиЭн-ийн Санхүүжүүлэгч, эсхүл Айвенхоугийн өөр Хувь нийлүүлэгч, эсхүл Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн гүйцэтгэж болохыг Талууд харилцан зөвшөөрөв (ОТН нь Шаардсан мөнгөн хөрөнгийг нийлүүлэх өөрийн болон АйВиЭн-ийн бүх үүргийг гүйцэтгэж болох бөгөөд энэ тохиолдолд АйВиЭн Шаардсан мөнгөн хөрөнгийг нийлүүлэхгүй).

(б) ТУЗ өөрөөр шийдвэрлээгүй тохиолдолд Шаардсан мөнгөн хөрөнгийн бүх нийлүүлэлтийг ам.доллараар хийнэ. ТУЗ өөрөөр шийдвэрлэсэн тохиолдолд Талууд энэхүү Гэрээний 9.1-д заасны дагуу хүргүүлсэн Шаардсан мөнгөн хөрөнгийн мэдэгдэлд заасан нэг, эсхүл хэд хэдэн валютаар нийлүүлэлтийг хийнэ.

9.4 Шаардсан мөнгөн хөрөнгийг нийлүүлэх хүсэлт гаргах хугацаа

(а) Гүйцэтгэлийн өдөр болон түүнээс хойш энэхүү Гэрээний 9.1-д заасан мөнгөн хөрөнгө нийлүүлэх хүсэлтийг хуанлийн Улирал тутам (эсхүл шаардлагатай тохиолдолд үүнээс богино хугацаанд) тавьж болох бөгөөд уг хүсэлтийг тухайн Улирал (эсхүл өөр холбогдох хугацаанд) эхлэхээс өмнө Хувь нийлүүлэгчдэд хүргүүлсэн байна.

(б) Энэхүү Гэрээний 8.1(а)-д заасны дагуу баталсан хөтөлбөр болон төсвийн хувьд тухайн хөтөлбөр болон төсвийг баталсан даруйд мөнгөн хөрөнгө нийлүүлэх анхны хүсэлтийг гаргаж болно.

9.5 Шаардсан мөнгөн хөрөнгийн төлбөр хийх хугацаа

Шаардсан мөнгөн хөрөнгийг энэхүү Гэрээний 9.1-д заасан хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 30 (гуч) хоногийн дотор Компанид төлнө.

9.6 Энэхүү Гэрээний 9 дүгээр зүйлийг хэрэглэх

Компани нь энэхүү Гэрээний 5.10(а)(v), эсхүл Компанийн тухай Монгол Улсын хуулийн 26.1-д заасны дагуу Компанийг татан буулгах ажиллагаа эхэлснээс хойш Шаардсан мөнгөн хөрөнгө нийлүүлэх хүсэлт гаргахгүй.

Гарын үсэг /Signature/ .....
20 11 оны 06 сарын 03 өдөр
Улаанбаатар хот

9.7 Хувь нийлүүлэгчийн одоогийн зээлийн хүү

Хувь нийлүүлэгчийн одоогийн зээлийн хүүг Гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн тооцож эхэлнэ.

9.8 Хувь нийлүүлэгчдийн одоогийн зээлийг хөрвүүлэх

(а) Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид Компани болон бусад Хувь нийлүүлэгч тус бүрд мэдэгдэл өгөх замаар дараахь шийдвэрийн аль нэгийг хэдийд ч гаргаж болно. Үүнд:

(i) Хувь нийлүүлэгчдийн одоогийн зээлийг энэхүү Гэрээний 9.8.(б)-д заасны дагуу Хувьцаанд хөрвүүлэх ба/эсхүл;

(ii) Хувь нийлүүлэгчдийн одоогийн зээлийг энэхүү Гэрээний 13.1-д заасан Хувь нийлүүлэгчдийн зээл гэж тооцож болох бөгөөд ингэж шийдвэрлэсэн тохиолдолд энэхүү Гэрээний 13.1(г) - 13.1(е) дэх заалтууд Хувь нийлүүлэгчдийн одоогийн зээлд үйлчилнэ.

Эдгээр шийдвэр нь Хөрвүүлэх өдөр болон түүнээс хойш хүчин төгөлдөр болно.

(б) Хэрэв АйВиЭн-ийн Хувь нийлүүлэгчид Хувь нийлүүлэгчдийн одоогийн зээлийг Гэрээний 9.8.(а)(i)-д заасны дагуу Хувьцаанд хөрвүүлэхээр шийдвэрлэсэн бол:

(i) Хөрвүүлэх үед Компани Хөрвүүлэх өдрийн байдлаар Хувь нийлүүлэгчдийн одоогийн зээлийн нийт дүн (түүний дотор зээлийн үндсэн дүн, төлөгдөөгүй болон хуримтлагдсан бүх хүү)-тэй тэнцүү (*Зээлийг хөрвүүлэх дүн*) тооны Хувьцаа гаргана;

(ii) Ийм Хувьцааг гаргахдаа Хувь нийлүүлэгч тус бүрийн Эзэмшлийн хувь хэмжээнд хувь тэнцүүлэн хуваарилна;

(iii) Зээлийг хөрвүүлэх дүнгийн ТӨК-ийн Эзэмшлийн хувь хэмжээнд ногдох хэсгийг Санхүүжүүлсэн дүн гэж үзэх бөгөөд Үлдэгдэл дүн (энэхүү Гэрээний 11.1(г)-д заасны дагуу ийнхүү тооцсон Санхүүжүүлсэн дүнд Зээлийн гэрчилгээ олгоно)-д нэмж тооцно.

10. Санхүүжилтийн зохицуулалт

10.1 Санхүүжилтийн хугацаанд нийлүүлэх хөрөнгө

Санхүүжилтийн хугацаанд доорхи нөхцөл хангагдахыг Талууд харилцан тохиролцов. Үүнд:

Монгол Улсын Гадаад харилцааны яам
Албан ёсны орчуулга мөн
Гарын үсэг /Signature/ .....
Улаанбаатар хот
Ministry of Foreign Affairs and Trade of Mongolia
OFFICIAL TRANSLATION

(а) ТӨК Шаардсан мөнгөн хөрөнгийн өөрт ногдох хэсгийг энэхүү Гэрээний 11.1 болон 13.1-д заасны дагуу нийлүүлэх шийдвэр гаргах эрхтэй (гэхдээ ийм үүрэг хүлээхгүй);

(б) АйВиЭн-ийн санхүүжүүлэгч нь (энэхүү Гэрээний 11.1 болон 13.1-д заасны дагуу ТӨК өөрийн хэсгийг нийлүүлэх шийдвэр гаргах эрхийг харгалзан) нийт Шаардсан мөнгөн хөрөнгийг бүрэн хэмжээгээр нийлүүлэх

бөгөөд Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид нь энэхүү Гэрээний 9.2-т заасан санхүүжилтийн аль хэлбэр, эсхүл хэлбэрүүдийг эдгээр нийлүүлэлтийн хувьд хэрэглэхийг тодорхойлно (Хөрөнгө оруулалтын гэрээнд заасан "зээл, хөрөнгө оруулалтын харилцаа"-ны шаардлагыг баримтална).

10.2 Санхүүжилтийн хугацааны дараахь үе

(а) Санхүүжилтийн хугацаа дууссаны дараа Компани нь Шаардсан мөнгөн хөрөнгийг нийлүүлэх хүсэлтийг Хувь нийлүүлэгчдэд хэдийд ч тавьж болно. Хэрэв ТӨК энэхүү Гэрээний 11.1(а), эсхүл 13.1(а)-д заасны дагуу Шаардсан мөнгөн хөрөнгийг нийлүүлэхгүй гэж шийдвэрлэсэн (эсхүл ингэж шийдвэрлэсэн гэж тооцогдох) тохиолдолд Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид нь энэхүү Гэрээний 11.1(в), эсхүл 13.1(в)-д заасны дагуу тухайн Шаардсан мөнгөн хөрөнгийн ТӨК-ийн нийлүүлэхгүй байхаар шийдсэн хэсгийг нийлүүлж болно (гэхдээ ингэх үүрэг хүлээхгүй). Энэ тохиолдолд Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид нь энэхүү Гэрээний 11 болон 13-т заасан Санхүүжилтийн хэлбэрүүдийн аль хэлбэрийг хэрэглэхийг тодорхойлох бөгөөд ийнхүү тодорхойлсон хэлбэрийг ТӨК болон Компани хүлээн зөвшөөрнө. Эргэлзээ төрүүлэхгүй байх үүднээс, тодруулбал, ТӨК түүнээс Шаардсан мөнгөн хөрөнгийг бүхэлд нь, эсхүл түүний тодорхой хэсгийг нийлүүлэхгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд ТӨК-ийн Эзэмшлийн хувь хэмжээ (Төрийн эзэмшлийн хувьцааг гарган ТӨК-д шилжүүлсний дараахь 34 хувь) буурахгүй. ТӨК түүнээс Шаардсан мөнгөн хөрөнгийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн нийлүүлэхгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд Айвенхоугийн хувь нийлүүлэгчид ТӨК-д ногдох Шаардсан мөнгөн хөрөнгийг, түүнчлэн өөрийн Эзэмшлийн хувь хэмжээнд ногдох Шаардсан мөнгөн хөрөнгийг санхүүжүүлэх үүрэг хүлээхгүй. Ийм нөхцөл байдал үүссэн үед ТУЗ санхүүжилтийн бусад арга хэлбэрийг тодорхойлно.

(б) Санхүүжилтийн хугацааны явцад болон дараа Компанийн Хувьцааг Хувь нийлүүлэгч бүрд дараахь байдлаар гаргаж олгоно:

(i) Хувь нийлүүлэгч бүрийн Эзэмшлийн хувь хэмжээнд хамаарах Шаардсан мөнгөн хөрөнгийн хувь хэмжээгээр;

(ii) ижил нөхцөл, болзолтойгоор.

Монгол Улсын Гадаад харилцааны яам
Албан ёсны орчуулгачийн
Гарын үсэг /Signature/ .....
20 11 оны 06 сарын 08 өдөр
Улаанбаатар хот
Ministry of Foreign Affairs and Trade of Mongolia
OFFICIAL TRANSLATOR
ОМНОТОЛГОО ХХК

(в) Эргэлзээ төрүүлэхгүй байх үүднээс ТӨК Шаардсан мөнгөн хөрөнгийг нийлүүлэхгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд түүний Эзэмшлийн хувь хэмжээ (Төрийн эзэмшлийн хувьцааг гарган ТӨК-д шилжүүлсний дараахь 34 хувь)-г бууруулж болохгүй. Санхүүжилтийн хугацаа дууссаны дараа энэхүү Гэрээний 11-д заасан, эсхүл түүнтэй төстэй арга хэлбэрээр Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид санхүүжилт хийхээр шийдвэрлэж үүний улмаас АйВиЭн-ийн Хувь нийлүүлэгчдэд Хувьцаа олгох тохиолдолд ТӨК-д түүний Эзэмшлийн хувь хэмжээтэй тэнцэх Хувьцааг ижил нөхцөл, болзолтойгоор олгоно.

(г) Энэхүү Гэрээний 10.2-ын аливаа заалт нь ТӨК-аас Шаардсан мөнгөн хөрөнгийг санхүүжүүлэх ТӨК-ийн эрхийг хязгаарлахгүй бөгөөд Компани ийнхүү санхүүжүүлснийг нь хүлээн зөвшөөрнө.

10.3 Санхүүжилтийн зохицуулалт

Энэхүү Гэрээний 11 дүгээр зүйлд заасан энгийн хувьцааны санхүүжилтийн зохицуулалтад үл нийцсэн тэргүүн ээлжинд худалдан авах аливаа эрхээ хэрэгжүүлэхгүй байхаар Хувь нийлүүлэгчид харилцан тохиролцов.

11. Энгийн хувьцаа гаргах замаар санхүүжилт хийх

11.1 ТӨК-аас Шаардсан мөнгөн хөрөнгийг энгийн хувьцаа гаргах замаар санхүүжүүлэх

(а) Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид (Санхүүжилтийн хугацааны туршид), эсхүл ТУЗ (Санхүүжилтийн хугацаа дууссаны дараа) энгийн хувьцаа гаргах замаар санхүүжилт хийхээр тодорхойлсон тохиолдолд ТӨК түүнээс Шаардсан мөнгөн хөрөнгө бүрийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн нийлүүлэхээр шийдвэрлэж болно (гэхдээ ингэх үүрэг хүлээхгүй). ТӨК түүнээс Шаардсан мөнгөн хөрөнгийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн нийлүүлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд энэ тухайгаа Компани болон Айвенхоугийн Хувь нийлүүлэгчдэд урьдчилан бичгээр (Шаардсан мөнгөн хөрөнгийг нийлүүлэх тухай хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 5 (таван) Ажлын өдрийн дотор) мэдэгдэнэ. Хэрэв ТӨК энэ хугацаанд нийлүүлэхгүй гэж шийдвэрлэсэн бол ТӨК түүнээс Шаардсан мөнгөн хөрөнгийн холбогдох хэсгийг нийлүүлэхгүй гэж шийдвэрлэсэнд тооцогдоно. Санхүүжилтийн хугацаа дууссаны дараа Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид өөрийн Эзэмшлийн хувь хэмжээнд ногдох Шаардсан мөнгөн хөрөнгийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн нийлүүлэхгүй байхаар шийдвэрлэсэн тохиолдолд энэ тухайгаа Компани болон ТӨК-д бичгээр (Шаардсан мөнгөн хөрөнгийг нийлүүлэх тухай хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 5 (таван) Ажлын өдрийн дотор) урьдчилж мэдэгдэнэ. Хэрэв Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид энэ хугацаанд ийм шийдвэр гаргаагүй бол энэхүү Гэрээний 10.2(а)-д заасныг харгалзан түүнээс Шаардсан мөнгөн хөрөнгийг бүхэлд нь нийлүүлэхээр шийдвэрлэсэн гэж үзнэ.

Хөрөнгө Оруулалтын Гэрээтэй харилцааны яам
Албан ёсны орчуулгад мөн
20 оны сарын өдөр
Улаанбаатар хот
Ministry of Foreign Affairs and Trade of Mongolia
OFFICIAL TRANSLATION

(б) Санхүүжилтийн хугацааны туршид хэрэв ТӨК энгийн хувьцаа гаргах замаар түүнээс Шаардсан мөнгөн хөрөнгийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн нийлүүлэхгүй байхаар шийдвэрлэсэн (эсхүл шийдвэрлэсэн гэж тооцогдох) бол АйВиЭн-ийн санхүүжүүлэгч ТӨК-аас Шаардсан мөнгөн хөрөнгийн ТӨК-ийн нийлүүлэхгүй гэж шийдвэрлэсэн хэсгийг энэхүү Гэрээний 11-д заасны дагуу ТӨК-ийн нэрийн өмнөөс Компанид төлнө.

(в) Санхүүжилтийн хугацаа дууссаны дараа хэрэв ТӨК 5 (таван) Ажлын өдрийн дотор ТӨК-өөс Шаардсан мөнгөн хөрөнгийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн нийлүүлэхгүй байхаар шийдвэрлэсэн (эсхүл шийдвэрлэсэн гэж тооцогдох) бол энэхүү Гэрээний 11-т заасны дагуу АйВиЭн-ийн санхүүжүүлэгч 5 (таван) Ажлын өдрийн ТӨК-аас нийлүүлэхгүй байхаар шийдвэрлэсэн хэсгийг энгийн хувьцааны санхүүжилтийн хэлбэрээр ТӨК-ийн нэрийн өмнөөс Компанид нийлүүлэх шийдвэр гаргаж болно (гэхдээ ийм үүрэг хүлээхгүй).

(г) АйВиЭн-ийн санхүүжүүлэгчийн санхүүжүүлсэн, үүний үндсэн дээр ТӨК-д хувьцаа олгосон мөнгөн дүн тус бүр нь *Санхүүжүүлсэн дүн* болох бөгөөд энэ тохиолдолд Компани Санхүүжүүлсэн дүнг гэрчилсэн *Зээлийн гэрчилгээг* АйВиЭн-ийн санхүүжүүлэгчид (хувийг Хувь нийлүүлэгч бүрд) олгоно.

(д) Санхүүжилтийн хугацааны туршид болон уг хугацаа дууссаны дараа Компанийн Хувьцааг Хувь нийлүүлэгч бүрд дараахь байдлаар гаргаж олгоно:

(i) Хувь нийлүүлэгч бүрийн Эзэмшлийн хувь хэмжээнд хамаарах Шаардсан мөнгөн хөрөнгийн хувь хэмжээгээр;

(ii) ижил нөхцөл, болзолтойгоор.

Энэ тохиолдолд ТӨК түүнээс Шаардсан мөнгөн хөрөнгийг нийлүүлэхээр шийдвэрлэсэн эсэхээс үл хамааран ТӨК-ийн Эзэмшлийн хувь хэмжээ (Төрийн эзэмшлийн хувьцааг гарган ТӨК-д шилжүүлсний дараахь 34 хувь)-г түүний зөвшөөрөлгүйгээр бууруулахгүй байх нөхцөлийг хангасан байна.

(е) Гүйцэтгэлийн өдрөөс эхлэн Компанийн санхүүжилтийн төлөвлөгөөг тодорхойлохдоо Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид ТӨК-тай зөвлөлдөнө. Үүнд боломжит санхүүжүүлэгчдэд зориулсан танилцуулах ажил, хөрөнгө босгох бусад үйл ажиллагаанд ТӨК-ийг оролцуулах зэрэг орно.

(ё) ТӨК нь гагцхүү энэхүү Гэрээний 16.6-д заасны дагуу 100 (нэг зуун) хувь Төрийн өмчлөл болон хяналтад байх тохиолдолд энэхүү Гэрээний 11.1.(б)-д заасны дагуу Айвенхоугийн Санхүүжүүлэгч нь ТӨК-аас Шаардсан мөнгөн хөрөнгийг (бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн) ТӨК-ийн нэрийн өмнөөс Компанид төлөх үүрэг хүлээнэ.

Монгол Улсын Гадаад харилцааны яам
Албан ёсны орчуулга мөн
Гарын үсэг /Signature/
2011 оны 06 сарын 08 өдөр
Хэлмэчээр хэр хөт
Ministry of Foreign Affairs and Trade of Mongolia
OFFICIAL TRANSLATION

(ж) Хэрэв Шаардсан мөнгөн хөрөнгийг бүхэлд нь, эсхүл холбогдох хэсгийг нь ТӨК нийлүүлэхгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд ТӨК-ийн Эзэмшлийн хувь хэмжээ (Төрийн эзэмшлийн хувьцааг гарган ТӨК-д шилжүүлсний дараахь 34 хувь)-г бууруулж болохгүй бөгөөд энэхүү Гэрээний 11-д заасан, эсхүл түүнтэй төстэй арга хэлбэрээр Айвенхоугийн Санхүүжүүлэгч санхүүжилт хийхээр шийдвэрлэж үүний улмаас Айвенхоугийн Хувь нийлүүлэгчдэд Хувьцаа олгох тохиолдолд ТӨК-д түүний Эзэмшлийн хувь хэмжээтэй тэнцэх Хувьцааг ижил нөхцөл, болзолтойгоор олгоно.

(з) Санхүүжилтийн хугацааны туршид ТӨК-аас Шаардсан мөнгөн хөрөнгийг энэхүү Гэрээний 11, 13-т заасны дагуу ТӨК өөрөө нийлүүлэх эрхтэй бөгөөд ТӨК-ийн сонгосон санхүүжилтийн арга хэлбэрийн нөхцөл, болзол нь тухайн үеийн болон ирээдүйд авахаар төлөвлөж буй Төслийн аливаа санхүүжилттэй зөрчилдөхгүй, эсхүл саад болохгүй байхын зэрэгцээ АйВиЭн-ийн Компанид хийсэн санхүүжилтийн нөхцөл, болзлоос дутуугүй байна.

11.2 Санхүүжүүлсэн дүн

(а) АйВиЭн-ийн санхүүжүүлэгчийн Санхүүжүүлсэн дүнгүүдэд энэхүү Гэрээний 11.3-д заасны дагуу Санхүүжилтийн хүүгийн хувиар хүү тооцох бөгөөд АйВиЭн-ийн санхүүжүүлэгч (эсхүл хэрэв Айвенхоугийн Хувь нийлүүлэгчдээс чиглэл өгсөн бол АйВиЭн-ийн санхүүжүүлэгчийн нэрийн өмнөөс АйВиЭн, эсхүл ОТН) энэхүү Гэрээний 11.4-т заасны дагуу Үлдэгдэл дүн дуусгавар болох хүртэл төлбөр хүлээн авах эрхтэй. Гэхдээ энэ эрх нь энэхүү Гэрээний 16.6(в) болон 16.7(б)-д заасны дагуу Үлдэгдэл дүнг бүхэлд нь хүлээн авах АйВиЭн-ийн санхүүжүүлэгчийн эрхийг, эсхүл энэхүү Гэрээний 11.4(г) заалтын дагуу Үлдэгдэл дүнг бууруулах боломжийг хязгаарлахгүй.

(б) Нийт Санхүүжилтийн хувьцааны нийлбэр нь Компанийн Нийт хөрөнгийн 60 (жаран) хувиас хэтрэхгүй байна.

11.3 Санхүүжилтийн хүүгийн хувь

(а) Үлдэгдэл төлбөрт Улирал тутам хүү (энэхүү Гэрээний 11.3(д)(ii)-д тодорхойлсны дагуу) тооцох бөгөөд тухайн хуанлийн Улирал бүрийн Санхүүжилтийн хүүгийн хувиар тооцно.

(б) Энэхүү Гэрээний 11.3(а)-д заасныг хангах зорилгоор өнгөрсөн өдрүүдийн бодит тоо болон 360 (гурван зуун жаран) өдөр бүхий жилээр үндэслэн хүүг тооцно. Хуанлийн Улирал нь Ажлын өдөр дуусаагүй тохиолдолд тухайн хуанлийн Улирлыг дараагийн Ажлын өдөр хүртэл сунгаж тооцно.

(в) Энэхүү Гэрээний 11.3(а)-д заасны дагуу хүү хуримтлагдах тухай бүрээс хойш Хөрвүүлэх өдрөөс өмнө Үлдэгдэл төлбөрийн нийлбэр

дүнг АНУ-ын Хэрэглээний Үнийн Индексийн өмнөх Улирлын өөрчлөлтөд нийцүүлэн өөрчилнө. Хөрвүүлэх өдөр буюу түүнээс хойш Үлдэгдэл төлбөрийн дүнг АНУ-ын Хэрэглээний Үнийн Индекст нийцүүлэн өөрчлөхгүй.

(г) Компани шаардлагатай тохиолдолд Санхүүжилтийн хүүгийн хувьтай холбогдуулан санхүүжилтийн эрсдэлээс хамгаалах хувилбаруудыг авч үзэн, бүх Хувь нийлүүлэгчдийн ашиг сонирхолд хамгийн сайнаар нийцүүлэн ийм хувилбарын талаар шийдвэр гаргах нь зүйтэй гэдгийг Талууд хүлээн зөвшөөрч байна.

(д) Энэхүү Гэрээний зорилгоор:

(i) Хуанлийн улирлын **Санхүүжилтийн хүүгийн хувь** гэж:

(А) Хүчин төгөлдөр болох өдрөөс эхлэн Хөрвүүлэх өдрийн өмнөх өдөр хүртэлх хугацааны хувьд хуанлийн Улирлын хүүг хэлэх бөгөөд энэ нь жилийн 9,9 хувь бодит хувьтай тэнцэх бөгөөд;

(Б) Хөрвүүлэх өдөр болон түүнээс хойшхи хугацааны хувьд холбогдох Улиралд LIBOR дээр нэмэх нь 6.50 хувь байна;

Эргэлзээ төрүүлэхгүй байх үүднээс, тодруулбал энэхүү Гэрээний 11.3(д)(i)(Б)-д заасан LIBOR (холбогдох улирлын) дээр нэмэх нь 6.50 хувь гэсэн нь жилийн бодит хүү болно.

(ii) "**Үлдэгдэл төлбөр**" гэж тухайн үед хуримтлагдсан дараахь дүнгүүдийн нийлбэрээс энэхүү Гэрээний 11.4-т заасны дагуу ТӨК-аас тухайн хугацааг хүртэл төлж барагдуулсан төлбөрийн нийт дүнг хассаныг хэлнэ:

(А) АйВиЭн-ийн санхүүжүүлэгчээс тухайн хугацаа хүртэл төлсөн нийт Санхүүжилтийн дүн (түүний дотор энэхүү Гэрээний 9.8(б)(iii), эсхүл 12(а)(iii)-д заасны дагуу Санхүүжүүлсэн дүн гэж тооцогдох аливаа дүнг оролцуулан);

(Б) энэхүү Гэрээний 11.3(а)-д зааснаар тухайн хугацаанаас өмнө хуримтлагдсан хүүгийн нийт дүн;

(В) энэхүү Гэрээний 11.3(в)-д зааснаар тухайн хугацаа хүртэл Үлдэгдэл төлбөрийн дүнг АНУ-ын Хэрэглээний Үнийн Индексийн өөрчлөлтөөр тохируулсан нийт дүн (хэрэв хамааралтай бол).

(iii) "**АНУ-ын Хэрэглээний Үнийн Индекс**" гэж Америкийн Нэгдсэн Улсын Хөдөлмөрийн яамны харьяа Хөдөлмөрийн статистикийн товчооноос нийтэд хэвлэн гаргадаг

Гадаад харилцааны яам
Албан ёсны орчуулга мөн
Гарын үсэг /Signature/
2011 оны 06 сарын 08 өдөр
Ministry of Foreign Affairs and Trade
OFFICIAL TRANSLATION

CUUR0000SAO цувралын дугаар бүхий "Хотын нийт оршин суугч Хэрэглэгчдийн хэрэглээний үнийн индекс (CPI-U): зардал, өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний төрлөөр ангилан харуулсан АНУ-ын хотын дундаж" хэмээх индексийн 1 (нэг) дүгээр хүснэгтэд заасан улирал тутмын эцсийн жилийн индексийг, харин энэхүү индексийг хэвлэн гаргахгүй болсон тохиолдолд Хувь нийлүүлэгчид сайн санааны үүднээс хэлэлцээ хийх замаар харилцан зөвшөөрсөн шинэ, өөрчлөн найруулсан, эсхүл орлох индексийг, тийнхүү харилцан тохиролцож чадаагүй тохиолдолд Компанийн сонгосон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн аудит болон нягтлан бодох бүртгэлийн компанийн тодорхойлсон шинэ, өөрчлөн найруулсан, эсхүл орлох индексийг ойлгоно.

(е) ТӨК болон Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид жил бүр Үлдэгдэл төлбөрийн тооцоог хамтран баталгаажуулна.

(ё) Хөрвүүлэх өдрөөс хойш 7 (долоон) жил тутамд Санхүүжилтийн хүүгийн хувь болон энэхүү Гэрээний 13.1(г)(ii)-д заасан, түүнчлэн энэхүү Гэрээний 25-д заасан Хувь нийлүүлэгчдийн одоогийн зээлийн тодорхойлолтод буй хүүгийн хувийн зохистой байдлыг хянан үзэх бөгөөд эдгээр хувийг бүх Тал зөвшөөрснөөр өөрчилж болно.

11.4 Үлдэгдэл төлбөрийн дүнг бууруулах

(а) Компани нь энэхүү Гэрээний 15.2-т заасны дагуу бүх Үлдэгдэл төлбөрийг буцаан төлж дуусах хүртэл ТӨК-ийн эзэмшлийн Хувьцааны хувьд түүнд ногдох Ногдол ашиг болгон төлж буй бүх мөнгийг АйВиЭн-ийн санхүүжүүлэгчид төлнө (хэрэв Айвенхоугийн Хувь нийлүүлэгчдээс чиглэл өгсөн бол АйВиЭн-ийн санхүүжүүлэгчийн нэрийн өмнөөс АйВиЭн, эсхүл ОТН-д төлнө).

(б) ТӨК нь энэхүү Гэрээний 11.4(а)-д заасныг хэрэгжүүлэх зорилгоор энэхүү Гэрээний 15.2 болон 11.4-т заасны дагуу Үлдэгдэл төлбөрийг эргүүлэн төлж дуусах хүртэл өөрт ногдох Ногдол ашгийг бүхэлд нь АйВиЭн-ийн Санхүүжүүлэгчид (хэрэв Айвенхоугийн Хувь нийлүүлэгчдээс чиглэл өгсөн бол АйВиЭн-ийн санхүүжүүлэгчийн нэрийн өмнөөс АйВиЭн, эсхүл ОТН-д төлнө) шууд төлөхийг Компанид энэхүү Гэрээгээр эргэлт буцалтгүйгээр чиглэл болгож байна. АйВиЭн-ийн санхүүжүүлэгчид Үлдэгдэл дүнгийн төлбөрийг хүлээн авах нөхцөлийг хангах зорилгоор ТӨК-нь өөрийн ногдол ашгаараа баталгаа гаргаж байна.

(в) ТӨК-аас энэхүү Гэрээний 11.4-т заасны дагуу төлсөн аливаа төлбөрийг Үлдэгдэл төлбөрийг бууруулах зорилгоор АйВиЭн-ийн санхүүжүүлэгчид төлсөн төлбөрт тооцох бөгөөд эргэлзээ төрүүлэхгүй байх үүднээс уг төлбөрийг АйВиЭн, эсхүл ОТН-д төлсөн, эсхүл хүлээн авсан Ногдол ашиг гэж үзэхгүй.

(г) ТӨК нь энэхүү Гэрээний 11.4(а)-аас 11.4(в)-д (11.4(в)-г оролцуулж тооцно) заасан зохицуулалтын дагуу Үлдэгдэл төлбөрийг бууруулахаас гадна АйВиЭн-ийн санхүүжүүлэгчид (хэрэв Айвенхоугийн Хувь нийлүүлэгчдээс чиглэл өгсөн бол АйВиЭн-ийн санхүүжүүлэгчийн нэрийн өмнөөс АйВиЭн, эсхүл ОТН-д төлнө) шууд төлбөр хийх замаар Үлдэгдэл төлбөрийг бууруулах эрхтэй. Талууд ийм төлбөр хийх болон хүлээн авах хамгийн тохиромжтой аргыг харилцан тохиролцоно.

(д) Энэхүү Гэрээнд заасны дагуу ТӨК-ийн Ногдол ашгаар хариуцахаас бусад тохиолдолд ТӨК, эсхүл Монгол Улсын Засгийн газар нь Үлдэгдэл төлбөрийн аль ч хэсгийг өөрийн эд хөрөнгөөр хариуцахгүй болохыг Талууд харилцан тохиролцов.

11.5 Үл хязгаарлах, эсхүл эзэмшлийн хувь хэмжээг бууруулахгүй байх

Энэхүү Гэрээний аливаа заалт нь Компанийн тухай Монгол Улсын хуулийн дагуу давуу эрхийн хувьцаа гаргах Компанийн боломжийг хязгаарлахгүй боловч ТӨК-ийн Эзэмшлийн хувь хэмжээг бууруулахад нөлөөлөхүйц, Хувьцаанд шилжих давуу эрхийн аливаа хувьцааг Компани гаргаж болохгүй.

12. Санхүүжүүлэх хувьцааг хөрвүүлэх

(а) Хөрвүүлэх өдөр болон түүнээс хойш Өмнөх Хувь нийлүүлэгчдийн гэрээний 11.1-д заасны дагуу гаргасан төлөгдөөгүй байгаа бүх Санхүүжүүлэх хувьцааг дараахь заалтуудын дагуу Хувьцаанд хөрвүүлнэ. Үүнд:

(i) Хувьцааг хөрвүүлэхдээ Компани Хөрвүүлэх тухайн өдрийн байдлаарх Санхүүжүүлэх хувьцаа тус бүрийн нэрлэсэн үнэ болон эдгээр Санхүүжүүлэх хувьцаа тус бүрийн төлөгдөөгүй болон хуримтлагдсан ногдол ашгийн үнийн нийлбэр (хамтад нь ***Хөрвүүлэх дүн*** гэх)-тэй тэнцэх тооны Хувьцаа гаргана;

(ii) ийм Хувьцааг Хувь нийлүүлэгч тус бүрд тэдгээрийн холбогдох Эзэмшлийн хувь хэмжээнд хувь тэнцүүлэн олгоно;

(iii) Хөрвүүлэх дүнгийн 34 хувийг Санхүүжүүлсэн дүн гэж үзэх бөгөөд Үлдэгдэл төлбөрийн дүнд нэмж тооцно (ийм Санхүүжүүлсэн дүнгийн хувьд энэхүү Гэрээний 11.1(г)-д заасны дагуу Зээлийн гэрчилгээ олгоно);

(iv) Талууд Санхүүжүүлэх хувьцаа тус бүрийг шинээр гаргах шинэ Хувьцаагаар албан ёсоор солиход шаардлагатай бүх арга хэмжээг авч, шаардлагатай бүх баримт бичиг гарын үсэг зурах бөгөөд ийнхүү сольсны дараа Санхүүжүүлэх хувьцаа цаашид хүчин төгөлдөр бус болно.

Монгол Улсын Гадаад харилцааны яам
Албан ёсны орчуулга мөн
Ministry of Foreign Affairs and Trade of Mongolia
OFFICIAL TRANSLATION
OYU TOLGOI LLC

(б) Энэхүү Гэрээний 12-т заасны дагуу Хувьцаанд хөрвүүлэх хүртэл уг хөрвүүлэлтийг харгалзан, энэхүү Гэрээнд хэрхэн зохицуулснаас үл хамаарч, Санхүүжилтийн хувьцааны нөхцөл, болзлыг Өмнөх Хувь нийлүүлэгчдийн гэрээний 11 болон бусад заалтуудын дагуу зохицуулна.

13. Хувь нийлүүлэгчдийн зээлийн санхүүжилт

13.1 Хувь нийлүүлэгчийн зээл

(а) Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид (Санхүүжилтийн хугацааны туршид), эсхүл ТУЗ (санхүүжилтийн хугацаа дууссаны дараа) нь Хувь нийлүүлэгчдийн авах зээлийн хэлбэрээр санхүүжилт хийхээр шийдвэрлэсэн тохиолдолд ТӨК түүнээс Шаардсан мөнгөн хөрөнгийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн нийлүүлэх шийдвэр гаргаж болно (гэвч ингэх үүрэг хүлээхгүй). ТӨК түүнээс Шаардсан мөнгөн хөрөнгийг бүхэлд нь нийлүүлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд Компани болон Айвенхоугийн Хувь нийлүүлэгчдэд бичгээр (Шаардсан мөнгөн хөрөнгийг нийлүүлэх хүсэлт ирснээс хойш 5 (таван) Ажлын өдрийн дотор) урьдчилан мэдэгдэнэ. Хэрэв энэ хугацаанд ТӨК түүнээс Шаардсан мөнгөн хөрөнгийг бүхэлд нь нийлүүлэхгүй байх шийдвэр гаргасан бол ТӨК түүнээс Шаардсан холбогдох мөнгөн хөрөнгийг нийлүүлэхгүй байхаар шийдвэрлэсэнд тооцогдоно. Санхүүжилтийн хугацаа дууссаны дараа Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид өөрийн Эзэмшлийн хувь хэмжээнд ногдох Шаардсан мөнгөн хөрөнгийг бүхэлд нь, эсхүл түүний тодорхой хэсгийг нийлүүлэхгүй байхаар шийдвэрлэсэн тохиолдолд Компани болон ТӨК-д бичгээр (Шаардсан мөнгөн хөрөнгийг нийлүүлэх хүсэлт ирснээс хойш 5 (таван) Ажлын өдрийн дотор) урьдчилан мэдэгдэнэ. Хэрэв Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид энэ хугацаанд ийм шийдвэр гаргаагүй бол энэхүү Гэрээний 10.2(а)-д заасны дагуу түүнээс Шаардсан мөнгөн хөрөнгийг бүхэлд нь нийлүүлэхээр шийдвэрлэсэнд тооцогдоно.

(б) Санхүүжилтийн хугацааны туршид хэрэв ТӨК түүнээс Шаардсан мөнгөн хөрөнгийг бүхэлд нь, эсхүл түүний тодорхой хэсгийг Хувь нийлүүлэгчдийн зээл хэлбэрээр нийлүүлэхгүй байхаар шийдвэрлэсэн (эсхүл шийдвэрлэсэн гэж тооцогдох) бол АйВиЭн-ийн санхүүжүүлэгч энэхүү Гэрээний 13-т заасны дагуу ТӨК-ийн нийлүүлэхгүй байхаар шийдвэрлэсэн хэсгийг санхүүжүүлэх үүрэгтэй.

(в) Санхүүжилтийн хугацаа дууссаны дараа хэрэв ТӨК 5 (таван) Ажлын өдрийн дотор түүнээс Шаардсан мөнгөн хөрөнгийг бүхэлд нь, эсхүл түүний тодорхой хэсгийг нийлүүлэхгүй байхаар шийдвэрлэсэн (эсхүл шийдвэрлэсэн гэж тооцогдох) бол АйВиЭн-ийн санхүүжүүлэгч энэхүү гэрээний 13-т заасны дагуу ТӨК-ийн нийлүүлэхгүй байхаар шийдвэрлэсэн хэсгийг Ажлын дараагийн 5 (таван) Ажлын өдрийн Хувь нийлүүлэгчийн зээл хэлбэрээр санхүүжүүлэхээр шийдвэрлэж болно (гэхдээ ийм үүрэг хүлээхгүй).

(г) Хүүг Хувь нийлүүлэгчдийн зээл болон аливаа хуримтлагдсан хүүгийн нийлбэр дээр тооцох бөгөөд улирал тутамд хуримтлуулан дараахь хувь хэмжээгээр тооцно. Үүнд:

(i) Хүчин төгөлдөр болох өдрөөс эхлэн Хөрвүүлэх өдрийн өмнөх өдөр хүртэлх хугацааны хувьд хуанлийн улирал тутамд АНУ-ын Хэрэглээний Үнийн Индексээр тохируулсан Санхүүжилтийн улирал тутмын хүү;

(ii) Хөрвүүлэх өдөр болон түүнээс хойшхи хугацааны хувьд хуанлийн Улиралд LIBOR дээр нэмэх нь 6.50 хувь.

Эргэлзээ төрүүлэхгүй байх үүднээс, тодруулбал энэхүү Гэрээний 13.1(г)(ii)-д заасан LIBOR (холбогдох Улирлын) дээр нэмэх нь 6.50 хувь нь жилийн бодит хүү байна.

(д) Улирал тутмын төгсгөлд хүүг Хувь нийлүүлэгчийн урьдчилан өгсөн үндсэн дүн дээр нэмэх нь тухайн үе хүртэл хуримтлагдсан хүүг нэмсэн дүнгээс тухайн Хувь нийлүүлэгчид Компанийн эргүүлэн төлсөн бүх төлбөрийг хассан дүн дээр хүү тооцно. Хувь нийлүүлэгчдийн зээлийн нөхцөл, болзлыг тодорхойлсон зээлийн гэрээг Компани болон Хувь нийлүүлэгчдийн хооронд шуурхай байгуулна.

(е) Хүүг тооцохдоо бодитоор өнгөрсөн хоногийн тоог үндэслэх бөгөөд нэг жилийг 360 (гурван зуун жаран) хоногтойгоор тооцно. Хэрэв хуанлийн Улирал ажлын бус өдөр дуусч байгаа бол тухайн хуанлийн Улирлыг дараагийн Ажлын өдөр хүртэл сунгаж тооцно.

13.2. Хувь нийлүүлэгчдийн зээлийг тэргүүн ээлжинд эргүүлэн төлөх

Компани (энгийн хувьцаанд) Ногдол ашиг хуваарилахаас өмнө энэхүү Гэрээний 13.1-д заасан Хувь нийлүүлэгчийн зээлийг энэхүү Гэрээний 15.1(г)-д заасны дагуу буцаан төлнө.

14. Төслийн санхүүжилтийг гуравдагч этгээдээс авах

(а) Компанийн төлөвлөгдсөн мөнгөн хөрөнгийн хэрэгцээг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн санхүүгийн байгууллагаас Компани зээл авах замаар санхүүжүүлэх шийдвэрийг ТУЗ тухай бүр гаргаж болно (Төслийн санхүүжилт).

(б) Энэхүү Гэрээний 14(а)-д заасан ТУЗ-ийн эрх мэдлийг хязгаарлахгүйгээр Хувь нийлүүлэгчид арилжааны хувьд боломжтой хүчин чармайлтыг дайчлан дараахь зорилтыг хангахыг харилцан тохиролцов. Үүнд:

(i) хэрэв ОТ төслийн хувьд үр өгөөжтэй, зохистой байвал Төслийн санхүүжилтийг Компанийг санхүүжүүлэх тэргүүлэх

Гарын үсэг /Signature/ .....
20 11 оны 06 сарын 08 өдөр
Ministry of Foreign Affairs and Trade of Mongolia
OFFICIAL TRANSLATION
ЭРДЭНЭС МГЛ ХХ КОМПАНИ
"OYU TOLGOI LLC" ХХК

ач холбогдолтой механизм болгож ашиглах;

(ii) ОТ мэт төсөлд зориулан олон улсын банкны зах зээлээс төслийн санхүүжилт олгодог хамгийн сайн нөхцөлөөр ийм Төслийн санхүүжилтийг боломжтой хурдан хугацаанд авахад нь Компанид туслах

(в) Компанид зориулан аливаа Хувь нийлүүлэгч болон\эсхүл АйВиЭн-ийн санхүүжүүлэгч ОТ төсөлд зориулан гуравдагч талын Төслийн санхүүжилтийн хэлбэрээр авсан хөрөнгийн бүрэн хэмжээний өртөг зардал дээр татварын шаардлагыг харгалзан хураамж ногдуулах, эсхүл аливаа ашиг буюу нэмэлтийг дамжуулахгүй байхыг Хувь нийлүүлэгчид хүлээн зөвшөөрч байна.

(г) Хувь нийлүүлэгч бүр энэхүү Гэрээний 14(а)-д заасан санхүүжилтийг олж авахын тулд нөгөө талдаа болон Компанид зохих бүх дэмжлэгийг үзүүлэх бөгөөд санхүүжилтийн аливаа зохицуулалт нь Монгол Улсын Засгийн газрын, эсхүл ТӨК-ийн өмч хөрөнгөд нөлөөлөхгүй.

15. Ногдол ашиг хуваарилах

15.1 Ногдол ашиг төлөх

(а) Хэрэв тухайн Санхүүгийн жилд Компани нь Ногдол ашиг хуваарилахаар ашигтай ажилласан бол ТУЗ нь тэрхүү ашгийн 100 (нэг зуу)-аас доошгүй хувийг тус Санхүүгийн жил дууссанаас хойш 3 (гурван) сарын дотор мөнгөн хэлбэрээр Ногдол ашиг болгон хуваарилахаар зарлана. Ийнхүү зарлахдаа энэхүү Гэрээний 15.1(г), 15.2(в), түүнчлэн энэхүү Гэрээний 14-т заасан Төслийн санхүүжилтийг гуравдагч этгээдээс авсан нөхцөлийн дагуу хүлээсэн үүргийг тус тус харгалзан энэхүү Гэрээний 15-д заасан бусад заалтыг баримтална. Ийнхүү хуваарилахдаа, Компанийн ирээдүйн бэлэн мөнгөний хэрэгцээ (үүнд, болзошгүй өргөтгөлийн зардал, эргэлтийн болон үндсэн хөрөнгийн зардал, бусад бодит болон нөхцөлт өр төлбөрт шаардагдах хөрөнгө)-г хангахад хүрэлцэхүйц зохистой хэмжээний нөөц авч үлдэнэ.

(б) Энэхүү Гэрээний 15.1(а)-д заасан Ногдол ашиг болгон хуваарилах ашгийг аудит хийлгэсэн Компанийн жилийн үр дүнд тулгуурлан тогтоох бөгөөд ингэхдээ энэхүү Гэрээний 15.1(г)-д заасан шаардлагыг урьдчилан хангасан байна.

(в) ТУЗ нь явцын дунд Ногдол ашиг хуваарилахаар зарлаж болно.

(г) Энэхүү Гэрээний бусад заалтаас үл хамааран Компани нь дараахь үүргүүдийг дор дурдсан дарааллаар биелүүлээгүй тохиолдолд болон биелүүлж дуусах хүртэл Ногдол ашиг (энгийн хувьцаанд) хуваарилахгүй. Үүнд:

Монгол Улсын Гадаад харилцааны яам
Гарын үсэг /Signature/
Ministry of Foreign Affairs and Trade of Mongolia

(i) энэхүү Гэрээний 14-т заасан гуравдагч этгээдийн Төслийн санхүүжилтийг тухайн гуравдагч этгээдийн шаардсаны дагуу эхний ээлжинд буцаан төлөх;

(ii) Хувь нийлүүлэгчийн одоогийн зээлийг Компани бүрэн төлсөн байх;

(iii) энэхүү Гэрээний 13-т заасан Хувь нийлүүлэгчийн өрд тооцох аливаа хүү болон Санхүүжүүлэх хувьцаанд (тэдгээрийг энэхүү Гэрээний 12-т заасны дагуу Хувьцаанд хөрвүүлээгүй бол) ногдох бүх ногдол ашгийг Компани бүрэн төлсөн байх (дараалал нь нэг байна);

(iv) Энэхүү Гэрээний 13-т заасан Хувь нийлүүлэгчийн өрийн бүх үндсэн өрийг Компани бүрэн буцаан төлсөн байх болон бүх Санхүүжүүлэх хувьцаа (тэдгээрийг энэхүү Гэрээний 12-т заасны дагуу Хувьцаанд хөрвүүлээгүй бол)-ны хөрөнгийг Компани эргүүлэн авсан байх (дараалал нь нэг байна);

(v) давуу эрхийн хувьцаанд ногдох (Санхүүжүүлэх хувьцаанаас бусад) бүх ногдол ашгийг Компани бүрэн төлсөн байх, мөн давуу эрхийн нийт хувьцааг (Санхүүжүүлэх хувьцаанаас бусад) Компани эргүүлэн авсан байх.

15.2 ТӨК-д төлөх Ногдол ашгаас суутгах

(а) Энэхүү Гэрээний 11-д заасан Үлдэгдэл төлбөрийг (хэрэв үлдэгдэл төлбөр байгаа бол) буцаан төлөөгүй бол Компаниас аливаа Ногдол ашгийг ТӨК-д төлөхдөө дараахь дарааллыг эн тэргүүнд баримтална:

(i) эхлээд Үлдэгдэл төлбөрийг буцаан төлөх;

(ii) дараа нь ТӨК-д төлөх.

(б) Компани нь энэхүү Гэрээний 15.2(а)(i)-д заасны дагуу АйВиЭн-ийн санхүүжүүлэгчид Үлдэгдэл төлбөр төлөх нь ТӨК-д Ногдол ашиг төлөх үүргээ биелүүлж байгаатай ижилд тооцогдоно.

(в) Талууд өөрөөр тохиролцоогүй бол энэхүү Гэрээнд заасан хуваарилах зохицуулалтын дагуу Ногдол ашгийг хуваарилах нөхцөлийг хангах зорилгоор ТӨК нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 21.8-д заасан өөрт ногдох Ногдол ашгаа дайчлах эрхээ хэрэгжүүлэхгүй.

Монгол Улсын Гадаад харилцааны яам
Албан ёсны орчуулга мөн

Гарын үсэг /Signature/ .....
2011 оны 06 сарын 08-ны өдөр
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs and Trade of Mongolia
OFFICIAL TRANSLATION
TOLGOI LLC

16. Хувьцаа шилжүүлэх

16.1 Хувьцаа шилжүүлэх зөвшөөрөл

Энэхүү Гэрээнд (Гэрээний 16.3-т заасныг оролцуулан) тусгайлан заагаагүй бол аль нэг Хувь нийлүүлэгч нь бусад Хувь нийлүүлэгч (цаашид "**Бусад Хувь нийлүүлэгч**" гэх) нэг бүрийн зөвшөөрлийг урьдчилан бичгээр авахгүйгээр өөрийн Хувьцаагаа бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн (эсхүл өөрийн бүх Хувьцаа болон түүний тодорхой хэсэг Хувьцаанд ногдох ашиг сонирхлыг) Захиран зарцуулахгүй.

16.2 Тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг Хувьцаа шилжүүлэх үед хэрэглэх

(а) Хэрэв Хувьцааг энэхүү Гэрээний 16.2(б)-ээс 16.2(и)-д (16.2(и)-г оруулж тооцно) заасны дагуу шилжүүлэх бол энэхүү Гэрээний 16.3 болон 16.7-д заасныг баримтлан Хувь нийлүүлэгч нь өөрийн Хувьцааг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн шилжүүлж болно.

(б) Хэрэв Шилжүүлэгч нь өөрийн Хувьцааг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хүсвэл (цаашид "**Захиран зарцуулах хувьцаа**" гэх) уг Захиран зарцуулах хувьцаагаа Бусад Хувь нийлүүлэгч нэг бүрд тэргүүн ээлжинд санал болгоно.

(в) Энэхүү Гэрээний 16.2(б)-д заасны дагуу Шилжүүлэгч нь шилжүүлэх аливаа саналаа бичгээр (цаашид "**Шилжүүлэх мэдэгдэл**" гэх) гаргах бөгөөд Шилжүүлэх мэдэгдэлд дараахь зүйлсийг тусгана:

(i) Захиран зарцуулах хувьцааны тоо болон Захиран зарцуулах хувьцааны үнийг ам.доллараар (**Шилжүүлэх үнэ**);

(ii) Захиран зарцуулах хувьцааг худалдахаар санал болгож буй нөхцөл;

(iii) Шилжүүлэгчийн саналыг Бусад Хувь нийлүүлэгч хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Шилжүүлэгчээс Захиран зарцуулах хувьцаагаа худалдахаар санал болгож буй гуравдагч этгээд (цаашид "**Сонгогдсон гуравдагч этгээд**" гэх)-ийн тухай.

(г) Шилжүүлэх мэдэгдэл нь түүнд заасан нөхцөлийн дагуу Захиран зарцуулах хувьцааг ямар нэг нөхцөл, болзолгүйгээр худалдах санал болох бөгөөд Шилжүүлэх мэдэгдлийг Бусад Хувь нийлүүлэгчдэд хүргүүлсэн өдрөөс хойш 50 (тавин) Ажлын өдрийн дотор уг саналд Бусад Хувь нийлүүлэгч хариу өгөхөд нээлттэй байна (цаашид "**Санал гаргах хугацаа**" гэх).

(д) Санал гаргах хугацаанд Бусад Хувь нийлүүлэгчийн аль нэг нь Шилжүүлэх мэдэгдэлд санал болгосон Захиран зарцуулах хувьцааг бүхэлд нь худалдан авахаас татгалзаж байгаагаа, эсхүл

Гарын үсэг /Signature/ .....
2011 оны 06 сарын 08 өдөр
Улаанбаатар хот

саналыг хүлээн авч байгаагаа Шилжүүлэгчид бичгээр мэдэгдэж болно (ингэхдээ мэдэгдлийн хувийг Бусад Хувь нийлүүлэгчдэд хүргүүлнэ). Хэрэв 1 (нэг)-ээс дээш Бусад Хувь нийлүүлэгч байгаа бол Захиран зарцуулах хувьцааг тэдгээрт тус бүрт нь санал болгосонд тооцно. Хэрэв 1 (нэг)-ээс дээш Хувь нийлүүлэгч худалдаж авахаар зөвшөөрвөл (хамтдаа биш, харин тус тусдаа) тэдгээр нь Захиран зарцуулах хувьцааг тэдгээрийн нийт Эзэмшлийн хувь хэмжээн дэх өөрсдийн Эзэмшлийн хувь хэмжээнд тохируулан (эсхүл тэдгээр Бусад Хувь нийлүүлэгч өөрөөр тохирч Шилжүүлэгчид бичгээр мэдэгдсэн өөр хувь хэмжээгээр) худалдан авна.

(е) Хэрэв аль 1 (нэг), эсхүл түүнээс дээш Бусад Хувь нийлүүлэгч Захиран зарцуулах хувьцааг худалдах саналыг хүлээн зөвшөөрөөгүй бол үлдсэн Бусад Хувь нийлүүлэгч, эсхүл Хувь нийлүүлэгчид тэдгээрийн нийт Эзэмшлийн хувь хэмжээн дэх өөрсдийн Эзэмшлийн хувь хэмжээнд тохируулан (эсхүл тэдгээр Бусад Хувь нийлүүлэгч өөрөөр тохирч Шилжүүлэгчид мэдэгдсэн хувь хэмжээгээр) Захиран зарцуулах хувьцааг худалдах саналыг хүлээн зөвшөөрч болно.

(ё) Хэрэв аль 1 (нэг), эсхүл түүнээс дээш Бусад Хувь нийлүүлэгч нь бүх Захиран зарцуулах хувьцааг энэхүү Гэрээний 16.2(д) болон 16.2(е)-д заасан зохицуулалтын хэрэгжилтийн дараагаар, Санал гаргах хугацаа дуусахад хүлээн зөвшөөрөөгүй бол Шилжүүлэх мэдэгдэлд дурдсан саналаас татгалзсанд тооцно.

(ж) Аливаа шаардлагатай зөвшөөрөл авахаас бусад тохиолдолд энэхүү Гэрээний 16.2(б)-д заасны дагуу саналыг хүлээн зөвшөөрөх нь ямар нэг болзолгүй байна.

(з) Хэрэв 1 (нэг), эсхүл түүнээс дээш Бусад Хувь нийлүүлэгч нь бүх Захиран зарцуулах хувьцааг худалдаж авахаар зөвшөөрвөл Санал гаргах хугацааны сүүлчийн өдрөөс хойшхи 10 (арав) дахь Ажлын өдөр Шилжүүлэгч нь Захиран зарцуулах хувьцааг Шилжүүлэх үнээр худалдаж, холбогдох Бусад Хувь нийлүүлэгч, эсхүл Хувь нийлүүлэгчид худалдан авч Захиран зарцуулах хувьцааг шилжүүлж дуусгана.

(и) Энэхүү Гэрээний 16.2(б)-ээс 16.2(ж)-д (16.2(ж)-г оруулж тооцно) заасныг мөрдсөн боловч Захиран зарцуулах хувьцааг худалдан авах саналыг хүлээн авах санал ирээгүй бол энэхүү Гэрээний 16.7-д заасныг баримтлан Шилжүүлэгч нь Санал гаргах хугацаа дууссанаас хойш 90 (ерэн) хоногийн дотор Захиран зарцуулах хувьцаагаа хэсэгчлэхгүйгээр бүхэлд нь Сонгогдсон гуравдагч этгээдэд Шилжүүлэх үнээс доошгүй үнээр, Шилжүүлэх мэдэгдэлд заасан нөхцөлөөс илүүгүй нөхцөлөөр шилжүүлж болно.

(к) Санал гаргах хугацаа дууссанаас хойш 90 (ер) хоногийн дотор Захиран зарцуулах хувьцааг шилжүүлээгүй бол Шилжүүлэгч нь

Монгол Улсын гадаад харилцааны яам
Албан бичиг баримтыг
Гарын үсэг /Signature/ .....
2011 оны 06 сарын 08 өдөр
Ulaanbaatar
Ministry of Foreign affairs and Trade of Mongolia
OFFICIAL
ЭРДЭНЭС МГЛ ХК КОМПАНИ

энэхүү Гэрээний 16.2(б)-ээс 16.2(ж)-д (16.2(ж)-г оруулж тооцно) заасан шаардлагыг эхэлж хангахгүйгээр Захиран зарцуулах хувьцаагаа бусдад шилжүүлж болохгүй.

16.3 Зөвшөөрөгдсөн шилжүүлэг

(а) Хувь нийлүүлэгч, эсхүл давуу эрхтэй хувьцаа эзэмшигч болох Айвенхоу групп, эсхүл Рио Тинто группийн аливаа гишүүн нь өөрийн эзэмшиж буй Хувьцаа, эсхүл аливаа давуу эрхийн хувьцааг (аль холбогдох нь) аливаа бусад Хувь нийлүүлэгч, эсхүл давуу эрхийн хувьцаа эзэмшигчээс урьдчилан бичгээр зөвшөөрөл авахгүйгээр, эсхүл энэхүү Гэрээний 16.2-т заасан шаардлагыг эхэлж хангахгүйгээр тухайн группийнхээ аливаа бусад гишүүнд бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн шилжүүлж болно.

(б) ТӨК нь өөрийн эзэмшиж буй Хувьцаа, эсхүл аливаа давуу эрхийн хувьцааг (аль холбогдох нь) бусад Хувь нийлүүлэгчид, эсхүл давуу эрхийн хувьцаа эзэмшигчдээс урьдчилан бичгээр зөвшөөрөл авахгүйгээр Компанийн тухай Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан 100 (нэг зуун) хувь Төрийн өмчит, гагцхүү Төрийн хяналтад байдаг аливаа бусад компанид, эсхүл 16.2-д заасан шаардлагыг эхлэн хангахгүйгээр бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн шилжүүлж болно.

(в) Хөрөнгө оруулалтын гэрээний 1.9-д заасны дагуу Ашигт малтмалын тухай хуулийн 5.6-д заасан шаардлагыг хангах үүднээс Засгийн газарт шилжүүлсэн хувьцааны 10 (арав)-аас доошгүй хувийг Монгол Улсын Хөрөнгийн бирж дээр худалдах асуудлыг ТӨК хариуцах бөгөөд ийнхүү шилжүүлэх нь энэхүү Гэрээний 16-д заасан шилжүүлгийн хязгаарлалтуудад хамаарахгүй. Хөрөнгө оруулалтын гэрээний 1.9-д заасныг хязгаарлахгүйгээр Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид болон Компани нь энэхүү Гэрээний 16.3(в)-д заасны дагуу ТӨК-ийн хэрэгжүүлэх үүргийг гүйцэтгүүлэхийг шаардахгүй.

16.4 Хувьцааг барьцаалах тухай

Хувь нийлүүлэгч нь энэхүү Гэрээний 16.5-д зааснаас бусад тохиолдолд өөрийн эзэмшлийн Хувьцаагаа (эргэлзээ төрүүлэхгүй байх үүднээс, үүнд энэ Хувьцаатай холбоотойгоор эдлэх эрх хамаарна) бусдад баталгаа, барьцаа, төлбөр, үүргийн гүйцэтгэлийг хангах аливаа барьцаа (цаашид "**Барьцаа**" гэх)-нд тавьж үл болно.

16.5 Хувьцааг барьцаалах

(а) Энэхүү Гэрээний 16.5-т заасан зааліт нь мөн Гэрээний 14-д тодорхойлсон аливаа барьцаа, эсхүл гуравдагч этгээдийн Төслийн санхүүжилтийн зохицуулалтад (энэхүү Гэрээний 16.5-д заасан шаардлагууд нь тэрхүү санхүүжилтийг авахад шаардлагатай

Монгол Улсын Гадаад харилцааны яам
Албан ёсны орчуулга мөн
11 06 68

байсан ч) хамаарах шаардлагууд биш болохыг Талууд харилцан зөвшөөрөв.

(б) Энэхүү Гэрээний 16.5(г)-д зааснаас бусад тохиолдолд Хувь нийлүүлэгч нь зөвхөн дараахь нөхцөлд өөрийн эзэмшлийн Хувьцааг Барьцаалж болно (цаашид "**Зөвшөөрөгдсөн барьцаа**" гэх):

(i) Хувьцааг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн санхүүгийн байгууллагад энэхүү Гэрээний 14(а)-д заасан санхүүжилтийг авахтай холбогдуулан (Төслийн санхүүжилтийг гуравдагч этгээдээс авахтай холбоотой) Барьцаалах (цаашид "**Зөвшөөрөгдсөн барьцаалагч**" гэх);

(ii) тухайн Хувь нийлүүлэгч ТУЗ-д бичгээр урьдчилан мэдэгдсэн;

(iii) дараахь шаардлагыг урьдчилан хангасан. Үүнд:

(А) Зөвшөөрөгдсөн барьцаа нь бичгээр үйлдэгдсэн байх бөгөөд энэхүү Гэрээний 16.5-т заасан шаардлагыг хангасан байх;

(Б) Зөвшөөрөгдсөн барьцааны хувийг бусад Хувь нийлүүлэгч нэг бүрт тухайн баримт бичгийг үйлдэхээс доод тал нь 30 (гучин) Ажлын өдрийн өмнө хүргүүлсэн байх бөгөөд бусад Хувь нийлүүлэгч нэг бүрийн урьдчилан бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр (үйлдэхээс өмнө, эсхүл дараа) түүнд ямар нэгэн өөрчлөлт оруулахгүй;

(В) Зөвшөөрөгдсөн барьцаалагч нь бусад Хувь нийлүүлэгчид хүлээн зөвшөөрөхүйц хэлбэр бүхий, төлбөрийг төлөх асуудлаарх эрх, үүргийг тодорхойлсон баримт бичиг (deed of covenant)-т гарын үсэг зурж, Компанид болон Хувь нийлүүлэгч нэг бүрд хүргүүлнэ. Төлбөрийн гэрээгээр Зөвшөөрөгдсөн барьцаалагч Зөвшөөрөгдсөн барьцаатай холбоотойгоор эдлэх эрх нь:

(1) энэхүү Гэрээний дагуу байна;

(2) энэхүү Гэрээний 11.4 болон 15.2-т заасны дагуу ТӨК-д төлөх Ногдол ашгийг АйВиЭн, ОТН болон АйВиЭн-ийн санхүүжүүлэгч авсны дараа нээгдэнэ гэдгийг тус тус хүлээн зөвшөөрөв.

(в) Зөвшөөрөгдсөн барьцаа нь:

Төрийн Үйлчилгээний Газраас харилцааны яам
Албан ёсны орчуулга мөн
Гарын үсэг /Signature/ .....
2011 оны 06 сарын 08 өдөр
Улаанбаатар хот

(i) энэхүү Гэрээний дагуу Хувь нийлүүлэгчийн эдлэх аливаа эрх, эрх зүйн хамгаалалт, түүний дотор өр төлбөр (үүнд Үлдэгдэл төлбөр багтана) хүлээн авах эрхийг хөндөх, эсхүл түүнд нөлөөлөх ёсгүй;

(ii) Зөвшөөрөгдсөн барьцаалагч (эсхүл түүгээр дамжуулан эрх ашгаа илэрхийлж буй этгээд) нь аливаа худалдах эрхээ, эсхүл өөрийн баталгаатай холбоотой эрхээ эдлэх, эсхүл хэрэгжүүлэхдээ энэхүү Гэрээний 16 (энэхүү Гэрээний 16.2-т заасан тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг оролцуулан)-д заасныг баримтална;

(iii) Энэхүү Гэрээний 11.4 болон 15.2-т заасны дагуу ТӨК-д төлөх Ногдол ашгийг АйВиЭн, ОТН болон АйВиЭн-ийн Санхүүжүүлэгч тэргүүн ээлжинд авах эрхээ эдэлсний дараа Зөвшөөрөгдсөн барьцаалагчийн эрх нээгдэнэ гэдгийг тус тус тодорхой заана.

(г) Хувь нийлүүлэгчдээс бичгээр урьдчилан зөвшөөрөл авах болон 16.5(б) болон 16.5(в)-д заасан шаардлагууд нь Өмнөх Хувь нийлүүлэгчдийн гэрээнд гарын үсэг зурсан өдөр Айвенхоу групп болон Рио Тинто группын аль нэг гишүүний хоорондын аливаа Барьцаанд хамаарахгүй.

16.6 ТӨК-ийн өмчлөл ба хувьцааг хөрөнгийн биржээр арилжих

(а) Энэхүү Гэрээний 16.6(б)-д заасны дагуу Төр ТӨК-ийн хувьцааг хөрөнгийн биржээр арилжихаас бусад тохиолдолд ТӨК нь Оюу Толгой Төслийн хэрэгжих хугацааны туршид:

(i) 100 (нэг зуун) хувь Төрийн өмчлөлд;

(ii) Зөвхөн Төрийн хяналтад байна.

(б) Төр нь ТӨК дахь өөрийн хувьцаагаа Монголын Хөрөнгийн бирж, эсхүл олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн хөрөнгийн биржид гарган арилжиж болно.

(в) Хэрэв ТӨК 100 (нэг зуун) хувь Төрийн өмчлөлд болон түүний хяналтад байхаа больсон (тухайлбал, ТӨК-ийн хувьцааг хөрөнгийн биржээр дамжуулан арилжсаны үр дүнд) тохиолдолд Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид холбогдох шийдвэр гарган ТӨК-д бичгээр мэдэгдэл ирүүлмэгц тухайн үеийн аливаа Үлдэгдэл төлбөрийг АйВиЭн-ийн санхүүжүүлэгчид (хэрэв Айвенхоугийн Хувь нийлүүлэгчдээс чиглэл өгсөн бол АйВиЭн-ийн санхүүжүүлэгчийн нэрийн өмнөөс АйВиЭн, эсхүл ОТН-д төлнө) бүхэлд нь шууд төлөх үүрэг хүлээнэ.

Монгол Улсын Гадаад харилцааны яам
Албан ёсны орчуулга мөн
Гарын үсэг /Signature/ .....
2011 оны 06 сарын 08 өдөр
Улаанбаатар хот

16.7 Захиран зарцуулах хувьцаанд тавигдах бусад хязгаарлалт

Хувьцаа шилжүүлснийг бүртгэхээс өмнө Хувь нийлүүлэгч нь дор дурдсанаас бусад тохиолдолд өөрийн эзэмшлийн Хувьцааг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн Захиран зарцуулж болохгүй:

(а) (Захиран зарцуулах хувьцааг одоогийн Хувь нийлүүлэгчид шилжүүлэхээс бусад тохиолдолд) шилжүүлэн авагч нь Шилжүүлэгчийн үүргийг бүрэн хүлээн авч биелүүлэхээ зөвшөөрөн тухайн асуудлаарх эрх, үүргийг тодорхойлсон, Талуудын хүлээн зөвшөөрхүйц хэлбэр бүхий баримт бичиг (deed of accession and assumption)-ийг Талуудтай байгуулах;

(б) ТӨК Шилжүүлэгч байх тохиолдолд АйВиЭн-ийн санхүүжүүлэгчийн сонгосноор (энэ тухай ТӨК-д бичгээр мэдэгдэнэ):

(i) шилжүүлэн авагч, эсхүл ТӨК нь шилжүүлэх үед аливаа Үлдэгдэл төлбөрийг бүхэлд нь төлөх, эсхүл өөртөө авах; эсхүл

(ii) шилжүүлэн авагч нь аливаа Үлдэгдэл төлбөрийг, эсхүл хэрэв ТӨК өөрийн бүх Хувьцаагаа шилжүүлээгүй бол Компани шилжүүлгийг бүртгэхээс өмнө Шилжүүлэгчийн эзэмшиж байсан нийт Хувьцаанд шилжүүлж байгаа Хувьцааны эзлэх хувь хэмжээтэй ижил хэмжээний Үлдэгдэл төлбөрийг төлж барагдуулах үүргийг хүлээн авах (эргэлзээ төрүүлэхгүй байх үүднээс, энэхүү Гэрээний 15.2-т заасны дагуу шилжүүлэн авагч нь Ногдол ашиг авах эрхийг Үлдэгдэл төлбөрийг, эсхүл Үлдэгдэл төлбөрийн холбогдох хэсгийг бүрэн төлж барагдуулсны дараа эдэлнэ).

(в) аливаа Шилжүүлэгчийн хувьд шилжүүлэн авагч нь шилжүүлэх үед энэхүү Гэрээний нөхцөлийн дагуу Компанид, эсхүл бусад Хувь нийлүүлэгч бүрд Шилжүүлэгчийн төлөх ёстой бүх төлбөрийг Гэрээний 16.7(б)-д заасныг баримтлан Компанид болон тухайн Хувь нийлүүлэгч бүрд төлөх, эсхүл өөртөө авах;

(г) шилжүүлэн авагч нь шаардлагатай бүх зөвшөөрлийг авах.

16.8 Хүчин төгөлдөр бус шилжүүлэг

Энэхүү Гэрээний 16-д заасныг зөрчиж хийсэн аливаа шилжүүлгийг Компани бүртгэхгүй. Ийнхүү хийсэн шилжүүлэг нь хүчин төгөлдөр бус байна.

16.9 Энэхүү Гэрээнд заасан эрхээ шилжүүлэх

Энэхүү Гэрээний 16-д заасны дагуу Хувьцаа шилжүүлэхээс бусад тохиолдолд аль нэг Тал нь бусад Талуудын зөвшөөрлийг урьдчилан

Албан ёсны орчуулга мөн
Гарын үсэг /Signature/ .....
20 11 оны 06 сарын 08-ны өдөр
Ministry of Foreign Affairs and Trade of Mongolia
OFFICIAL TRANSLATION

бичгээр авахгүйгээр энэхүү Гэрээгээр олгогдсон эрхээ бусдад шилжүүлэх буюу шилжүүлэх оролдлого хийх ёсгүй.

16.10 Компани дахь хувь эзэмшлээ 16 хувиар нэмэгдүүлэх ТӨК-ийн опцион эрх

(а) ТӨК нь Компанийн нийт хөрөнгөд (цаашид "**Опцион эрхийн хувьцаа**" гэх) эзэмших хувь хэмжээгээ нэмэгдүүлэх опцион эрх (цаашид "**Опцион эрх**" гэх)-тэй бөгөөд энэхүү эрхээ хэрэгжүүлснээр ТӨК нь Компанийн гаргасан нийт энгийн хувьцааны 16 (арван зургаан) хувийг нэмж эзэмших болно. Ингэхдээ опционыг ТӨК болон Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид харилцан зөвшөөрсөн нөхцөлөөр хэрэгжүүлнэ.

(б) Уг Опцион эрхээ ТӨК нь Хөрөнгө оруулалтын гэрээний хугацааг тэрхүү Гэрээний 16.11-д заасны дагуу анх удаа сунгасан өдрөөс хойш 1 (нэг) жилийн дотор Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид болон Компанид зөвхөн бичгээр мэдэгдсэнээр л эдэлж болно.

(в) Опцион эрхийн хувьцааг ТӨК авснаар Компани дахь Хувь нийлүүлэгчдийн Эзэмшлийн хувь хэмжээ дараахь байдалтай болно:

(i) ТӨК – 50 (тавин) хувь;

(ii) Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид - 50 (тавин) хувь.

(г) Энэхүү Гэрээний 16-д заасны дагуу ТӨК Опцион эрхийн хувьцааг авснаас үл хамааран Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид нь Оюу Толгой төслийн менежментийн эрхийг бүрэн хэмжээгээр, хязгаарлалтгүйгээр хадгалах бөгөөд Компанийн ТУЗ-ийн бүх хурал болон Хувь нийлүүлэгчдийн бүх хуралд 5.10(а)(viii)-аас 5.10(а)(xvi) (5.10(а)(xvi)-г оруулж тооцно)-д заасан асуудлаар шийдвэрлэх саналын эрхтэй байна. Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид болон ТӨК нь энэхүү Гэрээний 16.10(г)-д заасныг хэрэгжүүлэх зорилгоор Хувь нийлүүлэгчдийн гэрээнд болон бусад бичиг баримтад шаардлагатай өөрчлөлтийг хийнэ.

17. Мэдэгдэл болон баталгаа

(а) Гэрээний Тал тус бүр нөгөө талдаа дараахь мэдэгдэл ба баталгааг гаргаж байна. Үүнд:

(i) тухайн Тал нь өөрийн үүсгэн байгуулагдсан улсынхаа хууль тогтоомжийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж буй компани мөн (ТӨК-ийн хувьд тухайн компани нь Компанийн тухай Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан бөгөөд энэ хуулийн дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулна);

Гадаад харилцааны яам
Улаанбаатар хот

(ii) энэхүү Гэрээг байгуулах болон энэхүү Гэрээнд заасан өөрийн үүргээ биелүүлэх, үйл ажиллагаагаа хэвээр явуулах, эсхүл ирээдүйд төлөвлөснөөр явуулах эрхтэй.

(б) Компани, Хувь нийлүүлэгчид (тэдгээрийн Хамаарал бүхий компани) болон Менежментийн багийн Нууцын зэрэглэлтэй мэдээллийн хувьд ТУЗ-өөс тухай бүр тодорхойлсон нууцлалтай холбоотой үүргийг Талууд заавал дагаж мөрдөнө. ТУЗ нь энэхүү нууцлалын үүргийг тодорхойлохдоо Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу мэдээлэл гаргаж өгөх шаардлага, санхүүгийн тайлан гаргах шаардлага болон бизнесийн чухал мэдээллийн хамгаалалт зэргийг харгалзан үзнэ. ТУЗ-өөс шаардсан тохиолдолд Хувь нийлүүлэгч бүр өөрийн томилсон ТУЗ-ийн гишүүд, албан хаагч, ажилтан, гэрээт гүйцэтгэгч, эсхүл тэдгээрийн төлөөлөгчөөр Нууцын зэрэглэлтэй мэдээллийг задруулахгүй байх үүрэг хүлээлгэсэн баримт бичигт гарын үсэг зуруулна. Хувь нийлүүлэгч бүр өөрийн томилсон ТУЗ-ийн гишүүд, эсхүл Хувь нийлүүлэгчийн албан хаагч, ажилтан, гэрээт гүйцэтгэгч, эсхүл тэдгээрийн төлөөлөгч Нууцын зэрэглэлтэй мэдээллийг зөвшөөрөлгүйгээр задруулсан, урвуулан ашигласнаас үүдэн гарах хариуцлагыг хүлээнэ.

(в) ТӨК нь Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж байгаагийн хувьд Нууцын зэрэглэлтэй мэдээлэл болон өөрийн үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай бусад мэдээллийг Монгол Улсын Засгийн газарт мэдээлж (задруулж) болохыг Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид хүлээн зөвшөөрч байна.

18. ТӨК-ийн амлалт

Дараахь хэлцлүүдийн аль нэг хэлцлийн үр дүнд Компанийн энгийн, эсхүл давуу эрхийн хувьцаа эзэмшигч болсон, эсхүл байж болох Айвенхоу групп, эсхүл Рио Тинтод группын Хамаарал бүхий аливаа компанид төлөх ёстой Төрөөс ногдуулсан татварыг ТӨК нь Хөрөнгө оруулалтын гэрээний 2.27-д заасны дагуу төлнө. Үүнд:

(а) Компани Төрийн эзэмшлийн хувьцааг ТӨК-д шилжүүлэх, эсхүл олгох;

(б) энэхүү Гэрээний 11-д заасны дагуу ТӨК-ийн Компанид оруулах хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэхийн тулд ТӨК-д хийсэн санхүүжилт, эсхүл олгосон зээл (эсхүл түүнтэй төстэй зохицуулалт), түүний дотор үндсэн зээл, зээлийн хүүгийн төлбөр, түүнчлэн тэмдэгтийн хураамж, хэлцлийн татвар;

(в) энэхүү Гэрээний 13-т заасны дагуу ТӨК-ийн Компанид оруулах хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэхийн тулд Айвенхоу группын, эсхүл Рио Тинто группын аль нэг гишүүн ТӨК-ийн нэрийн өмнөөс буюу түүнд хамааралтайгаар хийсэн санхүүжилт, эсхүл олгосон

Албан ёсны орчуулга мөн
Гарын үсэг /Signature/
Ministry of Foreign Affairs and Trade of Mongolia
OFFICIAL

зээл (эсхүл түүнтэй төстэй зохицуулалт), түүний дотор үндсэн зээл, зээлийн хүүгийн төлбөр;

(г) энэхүү Гэрээний 20-д заасан Компанийн аливаа тусгай зөвшөөрлийг шилжүүлэх, эсхүл Хөрөнгө оруулалтын гэрээний 15.7.8-д заасны дагуу Компанид тусгай зөвшөөрөл, эсхүл эрхийг шилжүүлэх;

(д) ТӨК (эсхүл түүнийг залгамжлагч)-ийн эзэмшиж буй Хувьцаанд Компаниас тухай бүрд төлсөн Ногдол ашиг.

19. Гэрээний үйлчлэл

19.1 Хувь нийлүүлэгчдийн гэрээ нь Компанийн дүрмээс давуу байх

Хэрэв энэхүү Гэрээний заалт нь Компанийн дүрмийн заалттай зөрчилдөж байвал тухайн зөрчилтэй асуудлын хувьд энэхүү Гэрээний заалтыг баримтална.

19.2 Гэрээний заалтыг Компанийн дүрмийн заалтад тооцох

Энэхүү Гэрээний заалтыг түүний нөхцөлийн дагуу хүчин төгөлдөр байлгах зорилгоор Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл шинэ заалт оруулах шаардлагатай бол энэхүү Гэрээний холбогдох заалтыг Компанийн дүрмийн нэг хэсэг гэж тооцох бөгөөд шаардлагатай тохиолдолд Хувь нийлүүлэгчид Компанийн дүрэмд оруулах шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг дэмжсэн саналаар батална.

20. Оюу толгой төсөлд хамааралгүй тусгай зөвшөөрлийг шилжүүлэх

(а) Компани нь эзэмшиж буй тусгай зөвшөөрлүүдээ шилжүүлэх бөгөөд Оюу толгой төсөлд хамаарах бүх тусгай зөвшөөрөл (Өмнөх Хувь нийлүүлэгчдийн гэрээ байгуулахаас өмнө шилжүүлээгүй)-өө хадгалж, эзэмшинэ. Ийнхүү бүтцийн өөрчлөлт хийсний дараа Компани нь:

(i) 6709A тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл;

(ii) 6708A, 6710A тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл;

(iii) 6709A тоот тусгай зөвшөөрлийн талбайтай зэрэгцээ, эсхүл түүний эргэн тойрны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайгаас гэрээний дагуу ашиг хүртэх Компанийн эрхийг тус тус эзэмшинэ.

(б) Компани нь Оюу толгой төсөлд хамааралгүй бусад бүх тусгай зөвшөөрөл, түрээс, зөвшөөрөл болон бусад эрх (болон тэдгээрт холбогдох хөрөнгө) Айвенхоугийн Хувь нийлүүлэгчдийн сонгосон Монгол Улсын өөр этгээдэд шилжүүлнэ. Ингэснээр тухайн тусгай

зөвшөөрөл, эрх, холбогдох хөрөнгийг эзэмших Компанийн эрх дуусгавар болно.

(в) Энэхүү Гэрээний 20-д заасны дагуу хийх шилжүүлэг, хэлцлийг тэдгээр шилжүүлэг, хэлцлийг гүйцэтгэхэд шаардлагатай бүх зөвшөөрлийг Засгийн газраас өгснөөс хойш 45 (дөчин таван) Ажлын өдрийн дотор гүйцэтгэж дуусгана.

21. Харилцан хохиролгүй болгох

(а) Энэхүү Гэрээгээр хүлээсэн материаллаг үүргээ зөрчсөн тохиолдолд тухайн зөрчил гаргасан Хувь нийлүүлэгч нь уг зөрчлийн улмаас бусад Хувь нийлүүлэгч болон Компанид учирсан шууд хохирол, алдагдал, түүний дотор бүх өртөг, зардал, хүү, хууль зүйн үйлчилгээний хөлс, шинжээчийн хөлс болон бусад төлбөрийг нөхөн төлөх замаар бусад Хувь нийлүүлэгч болон Компанийг хохиролгүй болгоно.

(б) Нөхөн төлбөрийг хохирол учирсан, эсхүл алдагдал үүссэн өдрөөс хойш 60 (жар) хоногийн дотор төлнө. Нөхөн төлбөрийг ам.доллараар төлнө.

22. Гэрээний үргэлжлэх хугацаа болон Гэрээ дуусгавар болох

22.1 Өмнөх Хувь нийлүүлэгчдэд Гэрээ үйлчлэхгүй байх

Энэхүү Гэрээгээр зөвшөөрөгдсөний дагуу энэхүү Гэрээний 22.3-т заасныг баримтлан бүх Хувьцаагаа шилжүүлсэн Хувь нийлүүлэгчид энэхүү Гэрээ үйлчлэхгүй.

22.2 Гэрээний хугацаа

Энэхүү Гэрээ нь Компанийг татан буулгахаар шийдвэрлэх хүртэл, эсхүл Талууд энэхүү Гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгохоор бичгээр харилцан тохиролцох хүртэл бүхэлдээ хүчинтэй байж үйлчилнэ.

22.3 Гэрээ дуусгавар болох нь тодорхой заалтад нөлөөлөхгүй байх

Аливаа шалтгааны улмаас энэхүү Гэрээ дуусгавар болох болон аливаа Хувь нийлүүлэгч аливаа Хувьцаа эзэмших эрхгүй болох нь:

(а) Гэрээ дуусгавар болох, эсхүл түүнийг хүчингүй болгохоос өмнө бий болсон Талуудын бүрэн биелүүлээгүй аливаа үүргийг үл хөндөнө;

(б) Гэрээ дуусгавар болсноор, эсхүл түүнийг хүчингүй болгосноор хүчин төгөлдөр болохоор болон түүнээс хойш хүчинтэй хэвээр үлдэхээр энэхүү Гэрээнд заасан түүний аливаа заалтад нөлөөлөхгүй.

Монгол Улсын Гадаад харилцааны яам
Албан ёсны өрүүлга мэд
сэргээгдсэн/
2011 оны 06 сарын 08 өдөр
Улаанбаатар хот

23. Маргаан шийдвэрлэх

23.1 Маргааныг хэлэлцэн шийдвэрлэх

Энэхүү Гэрээнээс үүдэлтэй буюу түүнтэй холбоотойгоор Талуудын хооронд аливаа маргаан гарвал түүнийг эхний ээлжинд сайн санааны үндсэн дээр хэлэлцээ хийх замаар шийдвэрлэх бөгөөд аль нэг тал нь хэлэлцээ хийх хүсэлтийг бичгээр тавьснаас хойш 60 (жар) Ажлын өдөр, эсхүл өөрөөр тохиролцсон хугацааны дотор Талууд нэгдсэн шийдвэрт хүрч чадаагүй бол уг маргааныг энэхүү Гэрээний 23.2-т заасны дагуу шийдвэрлэнэ.

23.2 Арбитр

Энэхүү Гэрээний 23.1-д заасны дагуу маргааныг хэлэлцээний журмаар шийдвэрлэж чадаагүй бол түүнийг уг маргаан гарсан өдөр үйлчилж буй Нэгдсэн Үндэстний Байгууллагын Олон улсын худалдааны эрх зүйн комиссын Арбитрын Дүрэм /НҮБОУХЭЗК Дүрэм/-ийн дагуу заавал биелүүлэх арбитрын зарчмаар шийдвэрлэнэ. Арбитрын үйл ажиллагаа дараахь журмаар явагдана:

(а) арбитрчийн тоо 3 (гурав) байх;

(б) 3 (гурван) арбитрчийг НҮБОУХЭЗК-ийн Дүрмийн 7 болон 8-д заасан журмын дагуу томилох;

(в) арбитрын ажиллагааг Англи хэл дээр явуулах;

(г) арбитрын бүрэлдэхүүн Хувь нийлүүлэгчдийн гэрээг тайлбарлахдаа Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм журмыг хэрэглэх;

(д) арбитрын ажиллагааг явуулах газар нь Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Лондон хот байх;

(е) арбитрын ажиллагааг НҮБОУХЭЗК-ийн Дүрмийн дагуу Лондонгийн Олон улсын арбитрын Шүүх удирдан явуулах.

23.3 Арбитрын шийдвэрийг гүйцэтгэх болон хэрэгжүүлэх

Арбитрын шийдвэр нь эцсийнх байх бөгөөд уг шийдвэрийг Талууд заавал биелүүлнэ. Арбитрын шийдвэрийг түүнийг гүйцэтгэх эрх бүхий аливаа шүүхэд гүйцэтгүүлэхээр хүргүүлж болох бөгөөд ингэхдээ хамгийн түрүүнд Монгол Улсын зохих шүүхэд хүргүүлнэ. Хэрэв Монгол Улсын зохих шүүхэд хүргүүлсэн шийдвэрийг хүргүүлснээс хойш 30 (гуч) хоногийн дотор гүйцэтгээгүй бол эрх бүхий аливаа бусад шүүхэд хүргүүлж болно. Талууд арбитрын шийдвэрийг хүлээн авч биелүүлэх үүрэгтэйгээ хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд тухайн шийдвэрийг биелүүлэхээс аливаа хэлбэрээр зайлсхийхгүй байна.

23.4 Заалт хүчинтэй хэвээр үлдэх

Энэхүү Гэрээний 23-д заасан маргаан шийдвэрлэх журам нь энэхүү Гэрээ хүчин төгөлдөр байх хугацаанд болон Гэрээ түүний хугацаа дууссаны дараа, эсхүл хугацаанаас нь өмнө дуусгавар болгосны дараа энэхүү Гэрээтэй холбоотой, эсхүл түүнээс үүдсэн үйл ажиллагааны талаар Талуудын хоорондын гарсан аливаа маргаанд нэгэн адил хамаарна.

24. Бусад заалт

24.1 Мэдэгдэл

Энэхүү Гэрээний дагуу хүргүүлэх, эсхүл хийх аливаа мэдэгдэл, шаардлага, зөвшөөрөл, бусад харилцаа холбоо (цаашид "**Мэдэгдэл**" гэх)-г :

(а) бичгээр үйлдэж, илгээгчийн эрх олгосон этгээд гарын үсэг зурсан байна;

(б) Монгол Улсын нутаг дэвсгэрийн дотор хүргэх Мэдэгдлийн хувьд тухайн Мэдэгдлийг хүлээн авах ёстой этгээдэд биечлэн хүргэнэ. Хэрэв Монгол Улсын нутаг дэвсгэрээс гадна хүргэх Мэдэгдлийн хувьд тухайн Мэдэгдлийг биечлэн, эсхүл хүлээн зөвшөөрөгдсөн буухиа шуудангийн үйлчилгээгээр дор дурдсан хаягаар, эсхүл хүлээн авах ёстой этгээдээс илгээгчид хамгийн сүүлд мэдэгдсэн хаягаар тус тус хүргэнэ:

(i) ТӨК-д:
Монгол Улс
Улаанбаатар-15172
Чингэлтэй дүүрэг
1 дүгээр хороо
Жигжиджавын гудамж 6
Эрдэнэс МГЛ ХХК
Хэнд: Гүйцэтгэх захиралд
Факсын дугаар: +976 70110725

(ii) Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид:
АйВиЭн-д:
Айвенхоу Оюу Толгой (БиВиАй) Лимитед
9 Колумбус Центер Билдинг
Роуд Таун
Тортола
Британийн Виржинийн Арлууд
Хэнд: Компанийн нарийн бичгийн даргад

ОТН-д:
Оюу Толгой Нидерланд Би.Ви
200 Примс Бернхардплэйн
1097 ЖиБи

Монгол Улсын Гадаад харилцааны яам
Албан ёсны орчуулга мөн
Гарын үсэг /Signature/ .....
2011 оны 06 сарын 08-ны өдөр
Улаанбаатар хот

Амстердам
Нидерланд Улс
Хэнд: Компанийн нарийн бичгийн даргад

АйВиЭн болон ОТН-д (аль холбогдох нь)
(мэдэгдэлд тооцохгүй):

Оюу Толгой ХХК-иар дамжуулан
Монгол Улс
Улаанбаатар 14240
Чингисийн өргөн чөлөө-15
Сүхбаатар дүүрэг
Моннис цамхаг, 12 давхар
Хэнд: Ерөнхий захиралд
Факсын дугаар: +976 1133 1890

хувийг (мэдэгдэлд тооцохгүй):
Айвенхоу Майнз Лтд
999 Канад Плэйс
654 тоот
Ванкувер хот
Британийн Колумби Ви6Си 3И1
Канад Улс
Хэнд: Компанийн нарийн бичгийн даргад
Факсын дугаар: +1 604-682-2060

хувийг (мэдэгдэлд тооцохгүй):
Рио Тинто Интернейшнл Холдингс Лимитед
2 Ийстборн террас
Паддингтон
Лондон Ви26ЭлЖи
Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс
Хэнд: Компанийн нарийн бичгийн даргад
Факс: +44 20 7781 1800

(iii) Компанид:
Оюу Толгой ХХК-д
Монгол Улс
Улаанбаатар 14240
Чингисийн өргөн чөлөө-15
Сүхбаатар дүүрэг
Моннис цамхаг, 12 давхар
Хэнд: Ерөнхий захиралд
Факсын дугаар: +976 1133 1890

(в) дараахь нөхцөлд зохих ёсоор хүргүүлсэн, эсхүл хүлээлгэн өгсөнд тооцно:

(i) биечлэн хүргэж өгч буй бол гардуулсан мөчөөс;

Монгол Улсын Гадаад харилцааны яам
Албан ёсны орчуулга мөн
2011 оны 06 сарын 08 өдөр
Улаанбаатар хот

(ii) хүлээн зөвшөөрөгдсөн буухиа шуудангийн үйлчилгээг ашигласан тохиолдолд (тухайн улс доторх хаягаар илгээж буй бол) илгээснээс хойш 2 (хоёр) Ажлын өдрийн дараа, эсхүл (өөр улс дахь хаягаар илгээж буй бол) илгээснээс хойш 7 (долоо) Ажлын өдрийн дараа;

тус тус хүргэгдсэнд тооцно.

хэрэв Мэдэгдлийг зохих ёсоор хүргүүлсэн, эсхүл хүлээлгэн өгсөн өдөр нь тухайн мэдэгдлийг илгээсэн газрын Ажлын өдөр биш байсан бол, эсхүл 16.00 цагаас (тухайн орон нутгийн) хойш хүргүүлсэн бол тухайн газрын дараагийн Ажлын өдөр ажлын цаг эхлэхэд зохих ёсоор хүргүүлсэн, эсхүл хүлээлгэн өгсөнд тооцно.

(г) Англи, Монгол хэлээр үйлдэнэ.

24.2 Иргэний хуулийг хэрэглэх

Иргэний хуулийн 5.1, 5.2 болон 5.3 дахь заалтууд энэхүү Гэрээнд үйлчилнэ.

24.3 Хууль биелүүлэх

Хувь нийлүүлэгч болон түүний Хамаарал бүхий компани (аль холбогдох нь) нь авлигатай тэмцэх талаархи өөрийн үүсгэн байгуулагдсан улсын болон Монгол Улсын хууль тогтоомжийг дагаж мөрдөх бөгөөд Монгол Улсад явуулах үйл ажиллагаагаа эдгээр хуулийн хүрээнд явуулна.

24.4 Нэмэлт баталгаа

Талууд энэхүү Гэрээний заалтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай, эсхүл тохиромжтой бүх баримт бичгийг үйлдэн эмхэтгэж, хүргүүлэх талаар хамтарч ажиллана.

24.5 Гэрээний нэгдмэл байдал

Энэхүү Гэрээний заалтууд нь үүгээр зохицуулж буй асуудлаар Талуудын хүрсэн бүхий л тохиролцоог хамарч байгаа болно.

24.6 Нэмэлт, өөрчлөлт

Талууд зөвхөн өөр гэрээ байгуулах замаар энэхүү Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

24.7 Үйлчлэх хууль

Энэхүү Гэрээг Монгол Улсын хууль тогтоомж болон Монгол Улсын олон улсын гэрээний дагуу зохицуулж тайлбарлана.

Монгол Улсын Гадаад харилцааны яам
Албан ёсны орчуулга мөн
20 11 оны 06 сарын 08 өдөр
Улаанбаатар хот

24.8 Хэл

Энэхүү Гэрээг монгол, англи хэлээр тус бүр 6 (зургаан) эх хувь үйлдэх бөгөөд Талууд хэл тус бүр дээрх нэг хувийг хадгална. Монгол, англи хэл дээрхи эх бичвэрүүд адил хүчинтэй байх бөгөөд харин хоёр хэл дээрхи бичвэрүүдийн хооронд зөрүү гарвал англи эх бичвэрийг баримталж байхаар Талууд харилцан тохиролцов.

Монгол Улсын Гадаад харилцааны яам
Албан ёсны орчуулга мөн
Гарын үсэг /Signature/
20.11 оны 06 сарын 08 өдөр
Улаанбаатар хот
Ministry of Foreign
OFFI
TOLGOI LLC

25. Нэр томъёоны тодорхойлолт

"**Үндсэн хөрөнгийн зардал**" гэж Оюу толгой төсөл болон Үндсэн үйл ажиллагаатай холбоотойгоор олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн нягтлан бодох бүртгэлийн зарчмын дагуу үндсэн хөрөнгийн зардал гэж тооцогддог бүх өртөг, зардал, төлбөрийг хэлнэ.

"**Санхүүжилтийн хүүгийн хувь**" гэж энэхүү Гэрээний 11.3(д)(i)-д тодорхойлсон санхүүжилтийн хүүгийн хувийг хэлнэ.

"**Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эхэлсэн өдөр**" гэж Хөрөнгө оруулалтын гэрээний 16 дугаар бүлэгт тодорхойлсон утгатай ижил байна.

"**Гүйцэтгэлийн өдөр**" гэж Гэрээ хүчин төгөлдөр болох өдрөөс хойшхи 21 (хорин нэг) дэх Ажлын өдөр, эсхүл Талуудын харилцан тохиролцсон Гэрээ хүчин төгөлдөр болох өдрөөс хойшхи өөр өдрийг хэлнэ.

"**Гэрээт талбай**" гэж Хөрөнгө оруулалтын гэрээний 16 дугаар бүлэгт тодорхойлсон утгатай ижил байна.

"**Хяналт**" гэж аж ахуйн нэгжийн хувьд, тухайн аж ахуйн нэгжийн Хувь нийлүүлэгчдийн хурал дээр тоологдож болох саналын олонхийг шууд буюу шууд бусаар эдлэх эрхтэй, эсхүл тухайн аж ахуйн нэгжийн захирлуудын олонхийг шууд буюу шууд бусаар сонгох, эсхүл томилох эрхтэй байхыг хэлэх бөгөөд Хяналтыг нэр үгээр хэрэглэвэл түүнийг эзэмшигч нь өмнө дурдсан эрхээ эдлэх бололцоо олгож буй аливаа ашиг сонирхол гэсэн утгыг илэрхийлнэ. (**Хяналтад байгаа** гэж өмнөх утгатай холбогдуулан ойлгохыг хэлнэ).

"**Үндсэн үйл ажиллагаа**" гэж Хөрөнгө оруулалтын гэрээний 16 дугаар бүлэгт тодорхойлсон утгатай ижил байна.

"Хөрвүүлэх өдөр" гэж 2011 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийг хэлнэ.

"**ТУЗ-ийн гишүүн**" гэж Компанийн дүрэм болон энэхүү Гэрээний 5.3-т заасны дагуу Компанийн ТУЗ-ийн гишүүний албан тушаалд томилогдсон буюу сонгогдсон хүнийг хэлнэ.

"**Захиран зарцуулах хувьцаа**" гэж энэхүү Гэрээний 16.2(б)-д тодорхойлсон захиран зарцуулах хувьцааг хэлнэ.

"**Захиран зарцуулах**" гэж аливаа хөрөнгийн хувьд, түүнийг худалдах, шилжүүлэх, эрх шилжүүлэх, Барьцаалах, тухайн хөрөнгийн эзэмшигч болохоо зарлах, эсхүл түүний үр ашгаас татгалзах, эсхүл бусад байдлаар тухайн хөрөнгийг (эсхүл тухайн хөрөнгө дэх аливаа сонирхол буюу тухайн хөрөнгийн аливаа хэсэг) захиран зарцуулах, эсхүл ийнхүү оролдохыг хэлнэ.

"**Ногдол ашиг**" гэж Компани татвар төлсний дараахь Компанийн үйл ажиллагааны ашгаас Хувьцаанд хамааруулан төлөхөөр ТУЗ-өөс тогтоосон аливаа мөнгөн болон мөнгөн бус хуваарилалт (гэхдээ үүнд давуу эрхийн

Монгол Улсын Гадаад харилцааны яам
Албан ёсны орчуулга мөн
Гарын үсэг /Signature/
20 11 оны 06 сар 08
Улаанбаатар хот
Ministry of Foreign Affairs
OFFICIAL

хувьцаа, эсхүл Санхүүжүүлэх хувьцаанд төлөх ногдол ашиг хамаарахгүй)-ыг хэлнэ.

"**Хүчин төгөлдөр болох өдөр**" гэж Хөрөнгө оруулалтын гэрээний 16 дугаар бүлэгт тодорхойлсон утгатай ижил байх бөгөөд энэ нь 2010 оны 3 дугаар сарын 31-ний өдөр болно.

"**Хувь нийлүүлэгчийн одоогийн зээл**" гэж Гэрээ хүчин төгөлдөр болох өдөр хүртэлх хугацаанд Оюу толгой төсөл болон Үндсэн үйл ажиллагаатай холбогдуулан Айвенхоу групп, эсхүл Рио Тинто группээс Компанид урьдчилан олгосон бүх санхүүжилт (дүнг Хөрөнгө оруулалтын гэрээний 15.7.5 дахь заалтын дагуу тодорхойлно) (тухайн санхүүжилтийг олгосон нөхцөл болон түүнийг Компани Үйл ажиллагааны зардал, эсхүл Үндсэн хөрөнгийн зардалд зарцуулсан эсэхээс үл хамааран) түүнд тооцогдох хүүг энэхүү Гэрээний 9.8-д заасны дагуу тооцсоныг хэлэх бөгөөд үүнд:

(а) Хүчин төгөлдөр болох өдөр болон түүнээс хойш санхүүжилтийн дүнд 9,9 хувиар тооцсон жилийн бодит хүү багтана. Чингэхдээ энэ хүү нь АНУ-ын Хэрэглээний Үнийн Индексийн өмнөх Улирлын хэлбэлзлийн хувиар улирал тутам тогтоодог хувиудын нийлбэрээр тодорхойлогдоно.

(б) Хөрвүүлэх өдөр болон түүнээс хойш LIBOR (холбогдох улирлын) дээр нэмэх нь 6.5 хувь (энэ нь жилийн бодит хүү байна) багтана.

"**Санхүүгийн жил**" гэж 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацааг хэлнэ.

"**Санхүүжүүлсэн дүн**" гэж энэхүү Гэрээний 11.1(г)-д заасан утгыг илэрхийлнэ.

"**Санхүүжилтийн хувьцаа**" гэж Компанид аливаа нөхцөлгүйгээр Төслийн санхүүжилтийг олж өгснийг харгалзан 2012 оны 1 дүгээр сарын 1-нээс хойш Санхүүжилтийн хугацаа дуустал хугацаанд гаргасан энгийн хувьцааг хэлнэ.

"**Санхүүжилтийн хугацаа**" гэж Гүйцэтгэлийн өдрөөс эхлэн Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эхэлсэн өдрөөс хойш 3 (гурван) жил өнгөрөх хүртэлх хугацааг хэлнэ.

"**Санхүүжүүлэх хувьцаа**" гэж Өмнөх Хувь нийлүүлэгчдийн гэрээнд заасан утгыг илэрхийлнэ.

"**Төрийн эзэмшилийн хувьцаа**" гэж Гүйцэтгэлийн өдөр Компаниас гаргаж, ТӨК-д олгосон Хувьцааны тоог хэлэх бөгөөд ийнхүү олгосны дараа Компанийн Хувьцааны 34 (гучин дөрвөн) хувийг ТӨК эзэмшинэ.

"**Хөрөнгө оруулалтын гэрээ**" гэж Ашигт малтмалын тухай Монгол Улсын хуулийн 29 дүгээр зүйлд заасны дагуу Монгол Улсын Засгийн газар, Компани, Айвенхоу Майнз Лтд болон Рио Тинто Интернэшнл Холдингс Лимитедийн хооронд 2009 оны 10 дугаар сарын 6-ны өдөр Оюу толгой төсөлтэй холбоотойгоор байгуулсан Хөрөнгө оруулалтын гэрээг хэлнэ.

Албан ёсны орчуулга мөн

2011 оны 06 сарын 08 өдөр

Улаанбаатар хот

"**Айвенхоу групп**" гэж Айвенхоу Майнз Лтд (Канад Улсын Юкон мужид үүсгэн байгуулагдсан) болон түүний Хяналтад байгаа аливаа этгээдийг хэлнэ.

"**Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид**" гэж АйВиЭн болон ОТН-ийг хэлнэ.

"**АйВиЭн-ийн санхүүжүүлэгч**" гэж АйВиЭн, ОТН, эсхүл тэдгээрийн санал болгосон АйВиЭн, ОТН-ийн Хамаарал бүхий компани зэрэг бусад төлөөлөгчийг хэлнэ.

"**Зээлийг хөрвүүлэх дүн**" гэж энэхүү Гэрээний 9.8(б)(i)-д заасан утгыг илэрхийлнэ.

"Зээлийн гэрчилгээ" гэж энэхүү Гэрээний 11.1(г)-д заасан утгыг илэрхийлнэ.

*"**LIBOR**"* гэж холбогдох валютын хувьд (еврогоос бусад) аливаа Санхүүжүүлсэн дүнгийн хүүгийн хугацаа эхлэхээс өмнөх хоёр дахь Ажлын өдрийн Лондонгийн цагаар өглөөний 11.00 цагт, эсхүл тэр үед хэвлэн гаргадаг Британийн Банкируудын нийгэмлэгийн гурван сарын хүүгийн төлбөр тооцооны ханшийг хэлэх бөгөөд ийм ханшийг Ройтер агентлагийн мэдээллийн дэлгэцийн холбогдох хуудсаар орж авч болно (эсхүл энэ нь ажиллахгүй болсон бол холбогдох Санхүүжүүлсэн дүн, Хувь нийлүүлэгчдийн зээл, эсхүл Хувь нийлүүлэгчдийн одоогийн зээлийг гаргасан талын сайн санааны үндсэн дээр тодорхойлсон зохистой хүүг харуулсан өөр хуудас, эсхүл үйлчилгээ (Дэлгэцийн ханш)). Хэрэв Дэлгэцийн ханш тухайн валютын, эсхүл хугацааны хувьд байхгүй байвал дараахь хэлбэрээр тогтооно. Үүнд:

(а) 3 (гурван) сарын хугацаанд гаргасан ханшийг цаг хугацаагаар жигнэсний үндсэн дээр гаргасан хэлбэлзэх ханшуудын богино хугацаанд бол гурван сарын хугацаанд хамгийн ойр байх хугацаа, урт хугацаанд бол гурван сарын хугацаанд хамгийн ойр байх хугацааны туршийн арифметик дунджаар тогтоох бөгөөд шаардлагатай бол бутархайн 5 (таван) орноор бүхэлдэнэ;

(б) хэрэв 3 (гурван) сараас богино, эсхүл урт хугацаанд зарласан ханш байхгүй бол холбогдох Санхүүжүүлсэн дүн, Хувь нийлүүлэгчдийн зээл, эсхүл Хувь нийлүүлэгчдийн одоогийн зээлийг гаргасан талын хүсэлтээр олон улсын тэргүүлэх зэрэглэлийн банк, эсхүл банкуудын Лондонгийн банк хоорондын зах дээр хүүгийн хугацаа эхлэхээс өмнөх Ажлын хоёр дахь өдрийн өглөөний 11.00 цаг, эсхүл тэр үед зарласан ханшаар (бутархайн 5 (таван) орноор дээш нь бүхэлдэнэ) тооцно.

"**Менежментийн үйлчилгээний төлбөр**" гэж Хөрөнгө оруулалтын гэрээний 16 дугаар бүлэгт тодорхойлсон утгатай ижил байна

"**Менежментийн баг**" гэж энэхүү Гэрээний 7.2(а)-д тодорхойлсон менежментийн багийг хэлнэ.

"**Сонгогдсон гуравдагч этгээд**" гэж энэхүү Гэрээний 16.2(в)(iii)-д тодорхойлсон сонгогдсон гуравдагч этгээдийг хэлнэ.

Монгол Улсын Гадаад харилцааны яам
Албан ёсны орчуулга мөн
Гарын үсэг /Signature/
2011 оны 06 сарын 08

"**Мэдэгдэл**" гэж энэхүү Гэрээний 24.1-д тодорхойлсон мэдэгдлийг хэлнэ.

"**Санал гаргах хугацаа**" гэж энэхүү Гэрээний 16.2(г)-д тодорхойлсон хугацааг хэлнэ.

"**Үйл ажиллагааны зардал**" гэж Оюу толгой төсөл болон Үндсэн үйл ажиллагаатай холбоотойгоор Компани, эсхүл Менежментийн багийн, эсхүл тэдгээрийн өмнөөс гаргасан бүх өртөг, зардал, төлбөр (Үндсэн хөрөнгийн зардлаас бусад)-ийг хэлнэ.

"**Опцион эрх**" гэж энэхүү Гэрээний 16.10(а)-д тодорхойлсон опцион эрхийг хэлнэ.

"**Опцион эрхийн хувьцаа**" гэж энэхүү Гэрээний 16.10(а)-д тодорхойлсон опцион эрхийн хувьцааг хэлнэ.

"**Бусад Хувь нийлүүлэгч**" гэж энэхүү Гэрээний 16.1-д тодорхойлсон бусад хувь нийлүүлэгчийг хэлнэ.

"**Оюу толгой төсөл**" гэж Хөрөнгө оруулалтын гэрээний 16 дугаар бүлэгт тодорхойлсон утгатай ижил байна.

"**Үлдэгдэл төлбөр**" гэж энэхүү Гэрээний 11.3(д)(ii)-д тодорхойлсон үлдэгдэл төлбөрийг хэлнэ.

"**Дийлэнх олонхи**" гэж гуравны хоёр (2/3), эсхүл түүнээс дээш хувийг хэлнэ.

"**Тал**" гэж ТӨК, АйВиЭн, ОТН, Компани болон энэхүү Гэрээ, эсхүл Хөрөнгө оруулалтын гэрээний дагуу зөвшөөрөгдсөн тэдгээрийн залгамжлагч болон томилогдсон этгээд бүрийг хэлнэ.

"**Барьцаа**" гэж энэхүү Гэрээний 16.4-д тодорхойлсон барьцааг хэлнэ.

"**Эзэмшлийн хувь хэмжээ**" гэж Хувь нийлүүлэгчийн хувьд Компани дахь тухайн Хувь нийлүүлэгчийн шууд эзэмшдэг Хувьцаанд хамаарах Эзэмшлийн хувь хэмжээг хэлнэ (Төрийн эзэмшлийн хувьцааг гаргаж, ТӨК-д олгосны дараа ТӨК-ийн Эзэмшлийн хувь хэмжээ нь 34 (гучин дөрвөн) хувь байна).

"**Зөвшөөрөгдсөн барьцаа**" гэж энэхүү Гэрээний 16.5(б)-д тодорхойлсон зөвшөөрөгдсөн барьцааг хэлнэ.

"**Зөвшөөрөгдсөн барьцаалагч**" гэж энэхүү Гэрээний 16.5(б)(i)-д тодорхойлсон зөвшөөрөгдсөн барьцаалагчийг хэлнэ.

"**Өмнөх Хувь нийлүүлэгчдийн гэрээ**" гэж Оршил хэсэгт тодорхойлсон утгыг илэрхийлнэ.

"**Төслийн санхүүжилт**" гэж энэхүү Гэрээний 14(а)-д тодорхойлсон утгыг илэрхийлэх гуравдагч талын төслийн санхүүжилтийг хэлнэ.

Монгол Улсын Гадаад харилцааны яам
Албан ёсны орчуулга мөн
Гарын үсэг /Signature/ .....
2011 оны 06 сарын 08 өдөр
Ministry of Foreign Affairs
OFFICIAL TRANSLATION

"**Нууцын зэрэглэлтэй мэдээлэл**" гэж бусад Талд өгсөн Хувь нийлүүлэгч, эсхүл түүний Хамаарал бүхий компани, Компани, эсхүл Менежментийн багийн мэдээлэл бөгөөд үүнд технологи, процесс, бүтээгдэхүүн, техникийн үзүүлэлтүүд, шинэ бүтээл, худалдааны нууц, ноу-хау болон бизнесийн чухал бусад мэдээлэл зэрэг нууц шинж чанартай, олон нийтэд ил болоогүй мэдээлэл хамаарна (гэхдээ эдгээрээр хязгаарлагдахгүй).

"Улирал" гэж 1 дүгээр сарын 1, 4 дүгээр сарын 1, 7 дугаар сарын 1, эсхүл 10 дугаар сарын 1-ний өдрүүдээр эхлэх дараалсан гурван сарын хугацааг хэлнэ.

"**АНУ-ын Хэрэглээний Үнийн Индексээр тохируулсан Санхүүжилтийн улирал тутмын хүү**" гэж өмнөх улирал дахь АНУ-ын Хэрэглээний үнийн индексийн хэлбэлзлийн хувиар Улирал тутам тохируулдаг улирал тутмын хүүг хэлэх бөгөөд жилийн нийлбэр нь 9.9 хувь байна.

"**Хамаарал бүхий компани**" гэж:

(а) Айвенхоу группийн аливаа гишүүний хувьд - Айвенхоу групп болон Рио Тинто группийн аливаа өөр гишүүн;

(б) Рио Тинто группийн аливаа гишүүний хувьд - Рио Тинто группийн болон Айвенхоу группийн аливаа өөр гишүүн;

(в) ТӨК-ийн хувьд - Төрийн 100 (нэг зуун) хувийн өмчлөлд болон түүний Хяналтад байгаа аливаа өөр компанийг тус тус хэлнэ.

"**Хамааралтай хэлцэл**" гэж Компани /нэг талаас/ болон аливаа Хувь нийлүүлэгч, эсхүл аливаа Хувь нийлүүлэгчийн Хамаарал бүхий компани /нөгөө талаас/-ийн хооронд хийгдсэн гэрээний дагуу хийх нийт төлбөр нь нэг сая таван зуун мянган (1,5 сая) ам.доллараас хэтрэх аливаа хэлцэл (эргэлзээ төрүүлэхгүй байх үүднээс энэхүү Гэрээний 6.2-т заасан Хамааралтай хэлцлийн холбогдолтой заалтууд нь энэхүү Гэрээний 7.2(а)-д заасан Менежментийн багийг авч ажиллуулах гэрээнд хамаарахгүй)-ийг хэлнэ.

"**Тогтоол**" гэж Улсын Их Хурлын 2009 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн 57 дугаар тогтоолыг хэлнэ.

"**Рио Тинто групп**" гэж Рио Тинто Пи Эл Си (Англид үүсгэн байгуулагдсан), Рио Тинто Лимитед (Австрали Улсад үүсгэн байгуулагдсан) болон Рио Тинто Пи Эл Си болон/эсхүл Рио Тинто Лимитедийн Хяналтад буй аливаа этгээдийг хэлнэ.

"**Хувьцаа**" гэж Компанийн хөрөнгө дэх энгийн хувьцааг хэлнэ.

"**Хувь нийлүүлэгч**" гэж ТӨК, АйВиЭн болон ОТН болон Хувьцаа эзэмшиж буй аливаа бусад Талыг хэлнэ.

"**Хувь нийлүүлэгчийн өр**" гэж Гэрээ хүчин төгөлдөр болох өдөр, эсхүл түүнээс хойш Хувь нийлүүлэгчдээс, эсхүл тэдгээрийн нэрийн өмнөөс Компанид урьдчилан төлсөн нийт санхүүжилт, түүний дотор энэхүү Гэрээний 13-т заасны

Монгол Улсын Гадаад харилцааны яам
Албан ёсны орчуулга мөн
Гарын үсэг /Signature/
2011 оны 06 сарын 03 өдөр
Улаанбаатар хот
Ministry of Foreign Affairs
OFFICIAL

дагуу хийсэн санхүүжилтийн дүнгийн төлөгдөөгүй үлдэгдэл, түүнд тооцох хүүгийн нийлбэрийг хэлнэ.

"**ТӨК-аас Шаардсан мөнгөн хөрөнгө**" гэж Шаардсан мөнгөн хөрөнгө дэх ТӨК-ийн Эзэмшлийн хувь хэмжээг хэлнэ.

"**Төр**" гэж Монгол Улсыг хэлнэ.

"Нийт хөрөнгө" гэж Компанийн нийт санхүүжилтийн хэрэгцээг (өнгөрсөн болон ирээдүйн) санхүүжилтийн хугацааны төгсгөл хүртэл тооцсон дүн байх бөгөөд үүнд энгийн хувьцаа, давуу эрхийн хувьцаа, Хувь нийлүүлэгчдийн зээл, зээл, Төслийн аливаа санхүүжилтээр орсон болон Компанийн үйл ажиллагааны бэлэн мөнгөний урсгалаас орсон санхүүжилт хамрах бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй.

"**Шилжүүлэх мэдэгдэл**" гэж энэхүү Гэрээний 16.2(в)-д тодорхойлсон шилжүүлэх мэдэгдлийг хэлнэ.

"**Шилжүүлэх үнэ**" гэж энэхүү Гэрээний 16.2(в)(i)-д тодорхойлсон шилжүүлэх үнийг хэлнэ.

"**Шилжүүлэгч**" гэж энэхүү Гэрээний дагуу Хувьцаагаа бүгдийг нь, эсхүл хэсгийг нь шилжүүлэхээр санал болгож буй Хувь нийлүүлэгчийг хэлэх бөгөөд энэ нь Хувьцааны тухайн шилжүүлгийн бүртгэлийн өмнөх болон дараахь үеийн Хувь нийлүүлэгчийг илэрхийлнэ.

"**АНУ-ын Хэрэглээний Үнийн Индекс**" гэж энэхүү Гэрээний 11.3(в)(iii)-д тодорхойлсон АНУ-ын Хэрэглээний Үнийн Индексийг хэлнэ.

"**ам.доллар болон $**" гэж Америкийн Нэгдсэн Улсын хууль ёсны мөнгөн тэмдэгтийг хэлнэ.

"**Ажлын өдөр**" гэж Хөрөнгө оруулалтын гэрээний 16 дугаар бүлэгт тодорхойлсон утгатай ижил байна.

Монгол Улсын Гадаад харилцааны яам
Албан ёсны орчуулга мөн

Гарын үсэг /Signature/ .....
2011 оны 06 сарын 08өдөр
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs
OFFICIAL TRANSLATION

ДЭЭРХИЙГ НОТЛОН, энэхүү Гэрээг Улаанбаатар хотноо **2011 оны 6 дугаар сарын 8-ны өдөр** үйлдэж, гарын үсэг зурав.

Эрдэнэс МГЛ ХХК-ийг төлөөлж:



.....

Гүйцэтгэх захирал Б.Энэбиш


Айвенхоу Оюу Толгой (БиВиАй) Лтд-ийг төлөөлж:



.....

Хууль, эрх зүйн асуудал хариуцсан Дэд ерөнхийлөгч Жон Фониани

Оюу Толгой Нидерланд БиВи-ийг төлөөлж:



.....

Бизнес хөгжил хариуцсан Гүйцэтгэх дэд ерөнхийлөгч Сэм Риггал

Оюу Толгой ХХК-ийг төлөөлж:



.....

Ерөнхийлөгч бөгөөд Гүйцэтгэх ерөнхий захирал Камерон МакРэй

...лын Гадаад харилцааны яам
Албан ёсны орчуулга мөн

Гарын үсэг /Signature/ .....
2011 оны 06 сарын 08 өдөр
Улаанбаатар хот

Ministry of Foreign ...
OFFICIAL ...